

**“ҮЙЛДВЭРЖИЛТ 21-100” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
(2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл
1.	“Үйлдвэржилт 21-100” үндэсний хөтөлбөр (2018-2021) ЗГ-ын 36 дугаар тогтоол	Хөтөлбөрийн зорилго: Орон нутгийн онцлог, нөөцөд суурилан дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, нэмүү өртөг шингэсэн, олон улсын чанар, стандартын шаардлага хангасан, өрсөлдөх чадвартай зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байр, гадаад, дотоод худалдааны эргэлт, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт; Улсын болон орон нутгийн төсвийн дэмжлэг; Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө; Концессын гэрээ; Бусад эх үүсвэр.
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам, ГХЯ, ХНХЯ, БСПУСЯ, УУХҮЯ, БОАЖЯ, БХБЯ, ЭХЯ, БХЯ, ХЗДХЯ, ГЕГ, ТЕГ, МХЕГ, СХЗГ, МҮХАҮТ, Аймаг нийслэлийн ЗДТГ, ҮХГ, ХХМТГ, НУИГ, ОУБ, ШУТСан, Монгол банк, Хөгжлийн банк, ЕСББ, АХБ, СЗХороо, ДБМ лизинг, ЖДҮХС, ХААБ, ТЭДСан, МХС, МЭЕГ, Мэргэжлийн холбоод, ТББ, ШУА, ШУТИС болон бусад их дээд сургуулиуд, МСҮТ, ААН-үүд
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Үйлдвэрлэлийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, түүхий эд, бүтээгдэхүүний чанар, стандартыг нэвтрүүлэн нутагшуулж, олон улсын болон бүс нутгийн түвшинд хүргэх; Зорилт 2. Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, түүхий эдийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх Зорилт 3. Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, түүхий эдийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх Зорилт 4. боловсруулах үйлдвэрийн хөгжлийн чиг хандлага, эрэлтэд нийцүүлэн хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх; Зорилт 5. Зорилтот зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний тээвэр-ложистикийг боловсронгуй болгож, маркетингийн үйл ажиллагааг хөгжүүлэн дотоод, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх.
5.	Төсөв (нийт шаардагдах зардал, сая.төг)	Нийт-3.045.105.5
	Үүнд:	Төсөв (он) Гүйцэтгэл /Тэрбум төгрөг/ Хувь
	Улсын болон орон нутгийн төсөв	958.4 8.2 5.8
	Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө	915.9 21.4 2.3
	Концессийн гэрээ	565.1 - 0
	Хувийн хэвшил	605.7 32.7 5.4
	Бусад эх үүсвэр	25.6 - -
		3,045.1 87,9 2.9
	1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Үйлдвэрлэлийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, түүхий эд,	Хонь, тэмээний, ноос, арьс ширэнд урамшуулал олгох тухай Засгийн газрын тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах “Хонь, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт нийлүүлсэн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох” журмыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд 2018 онд урамшууллын падаанаар ноос худалдан авсан 108 ААН-ийн тайланг шалгаж, дүн шинжилгээ хийж, зөрчилтэй 43 ААН-ийг ХШДАГ, СХОГ-тай хамтарсан ажлын хэсэг байгуулан хяналт шалгалтын ажил хийсэн, 2019 онд урамшууллын падаан авах үйлдвэрүүдийн жагсаалтыг хянаж, баталгаажуулан МНБҮХ-д 3 удаа зөвлөмж, чиглэл өгч албан тоот хүргүүлсэн. Ажлын хэсгийн

<p>бүтээгдэхүүний чанарын стандартыг олон улсын болон бүс нутгийн түвшинд хүргэх, нэвтрүүлэн нутагшуулах;</p>	<p>хяналт шалгалт, тайлан, зөвлөмжид анализ хийсэн. ЗГ-ын 2019 оны 343 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан. Журмыг 2020.01.01-нээс эхлэн мөрдөж хэрэгжүүлэхийг ЗГ-ын 396 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж батлуулсан. ХШҮ- 100 %</p> <p>"Түүхий эдийг үйлдвэрт тогтвортой нийлүүлэн нэмүү өртгийн сүлжээ бий болгох боломж" судалгаа хийх Малчдаас бэлтгэсэн түүхий эдийг бүртгэлжүүлэх, чанарыг мөшгөх зорилгоор Ногоон алт-Малын эрүүл мэнд төслийн санхүүжилтээр 18 аймгийн 28 сумын хоршоо, сумын бэлчээр ашиглагчдын холбоог мөшгөх тогтолцооны RMTS цахим системд оруулж эхлээд байна. Мөн НҮБ-ын ХХ-ийн "Ноолуурын тогтвортой өртгийн сүлжээ" төслөөс Хэнтий аймгийн Норовлин, Дорнод аймгийн Цагаан-овоо, Баян-уул сумдад ноолууран түүхий эдийг блокчейн технологид суурилсан цахим системд бүртгэлжүүлэн мөшгих тогтолцоог туршиж хэрэгжүүлсэн. ХШҮ- 70 %</p> <p>1.3.Түүхий эдийн сангийн эх үүсвэр бий болгох шийдвэрийн төсөл боловсруулж батлуулах, санг бүрдүүлэх. 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 87 дугаар тогтоол батлагдсан. Уг тогтоолын дагуу ЗГ-ын тусгай сангийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахыг холбогдох ЗГ-ын гишүүдэд даалгасан. ЗГ-ын тусгай сангийн тухай хууль (шинэчилсэн найруулга) -ийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсны үндсэн дээр үзэл баримтлалын төслийг боловсруулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу хянуулж батлуулахаар судалгааны тайлан, үзэл баримтлалын төслийг СЯ боловсруулан яамдаас санал авч нэгтгэж байна. ХШҮ- 40 %</p> <p>Гааль, татвар, мэргэжлийн хяналтыг нэг цэгт үзүүлэх тогтолцоог бий болгох судалгаа хийх ГЕГ: АХБ-ны төслийн нэгжийн хууль, эрх зүйн дотоодын зөвлөх цахим нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хүрээнд хууль эрх зүйн орчин тухайлбал төрийн байгууллагын эрх зүйн орчныг судалж, хаалтын тайлангийн төсөл 2019 оны 3 сард хийгдсэн. Тус зөвлөхийн хууль, эрх зүйн орчинд хийсэн шинжилгээний тайланг УИХ-ын Зөвшөөрлийн тухай хуулийг санаачлагч, ажлын хэсгийн ахлагч С.Бямбацогт, ГХЯ, МХЕГ, ХХЕГ, ГИХГ, МҮХАУТ-д тус тус хүргүүлсэн. Гадаад худалдааны цахим нэг цонхны концепц, давуу талыг гадаад худалдаа эрхлэгчид болон төрийн байгууллагуудад танилцуулах видео танилцуулга/ сургалтын материалыг боловсруулж "Хилийн нэгдсэн удирдлага" нээлттэй хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгуулагдсан. ЗГ-аас хэрэгжүүлж буй гаалийн шинэчлэлийн хүрээнд хилээр нэвтэрч байгаа иргэд зорчигчид, бизнес эрхлэгчдэд шуурхай үйлчилгээ үзүүлэх, хяналт шалгалтад зарцуулдаг цаг хугацааг багасгах, хяналт шалгалтад хамрагдах зогсолтын тоог багасгах, нэг цэгт нэг дор хамтарч хяналт хийх, орчин үеийн шинэ техник технологи ашиглах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор Алтанбулаг, Замын-Үүд, Гашуунсухайт, Сүхбаатар, Бичигт боомтуудад өргөтгөл шинэчлэлт хийхээр төлөвлөн төлөвлөлтийн зураг төслийг гүйцэтгэсэн. Боомтуудын өргөтгөл шинэчлэлийн бүтээн байгуулалтын барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Уг бүтээн байгуулалт хийгдсэнээр боомтуудын нэвтрүүлэх хүчин чадал 2-4 дахин нэмэгдэж, гадаад худалдааны өсөлтөд чухал нөлөө үзүүлнэ. ХШҮ- 100 %</p> <p>Худалдааны тухай хуулийн төслийн боловсруулж, УИХ-д өргөн барих. ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2018 оны А-586 тоот тушаалаар "Худалдааны тухай" хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хурлыг 3 удаа зохион байгуулж, хуулийн төслийг боловсруулан олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээс гарсан санал зөвлөмжийг хуулийн төсөлд тусган боловсруулсан. /EU-TRAM/ төсөлтэй хамтран "Худалдааны тухай" хуулийн төслийг Англи хэл рүү хөрвүүлэн цаашид хамтран ажиллах арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна. ХШҮ- 70 %</p> <p>Түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулах, үйлдвэрүүд дотооддоо хоршин ажиллах үйл ажиллагааг дэмжсэн зохицуулалтын талаар Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах. Улсын Их хурлаас 2019 оны 3 дугаар сард баталсан "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай" хуульд түүхий эдийн үнийн дүнд нь 10 хувийн албан татвар шингэсэн гэж үзэж, тэдгээрийг худалдан авсан албан татвар суутган төлөгчийн албан татварыг уг хувиар хасалт хийх тухай 14.1.4 заалтад "ноос, ноолуур"-ыг нэмж оруулсан. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь ноос, ноолуурын үйлдвэрүүдэд ялангуяа кластераар ажиллаж буй үйлдвэрүүдэд татварын таатай орчныг бий болгож байна. ХШҮ- 100 %</p> <p>Хөдөө аж ахуйн биржийн журмыг шинэчлэх.</p>
---	---

	<p>Биржээр арилжих бараа, түүхий эдийн нэр төрлийг ХХААХҮ-ийн сайдын тушаалаар баталдаг бөгөөд одоогийн байдлаар 8 нэр төлийн түүхий эдийг тус биржээр арилжиж байна. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 5.1.7-д заасны дагуу арьс ширийг биржээр арилжихаар Биржийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/19 тоот тушаал гарсан. Үүний дагуу Биржийн Төлбөр тооцоо, ложистикийн журамд нэмэлт өөрчлөлт оруулж, мөрдөн ажиллаж байна. Энэ хүрээнд Биржийн үйл ажиллагааг өргөжүүлэх, технологийн шинэчлэл хийх зорилгоор Блокчэйн технологид суурилсан арилжаа, төлбөр тооцооны платформ нэвтрүүлэх ажлыг санаачлан ТУЗ-ийн хурлаар шийдвэр гаргуулан 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, “Айтүүлс” ХХК тендерт шалгарч, энэхүү ажлыг бүрэн хийж хүлээлгэн өглөө.</p> <p style="text-align: right;">ХШҮ- 70 %</p> <p>1.8. Дотоодод үйлдвэрлэх боломжгүй түүхий эд, бүтээгдэхүүн, туслах материалын импортын гаалийн болон НӨАТ-ыг бууруулах чиглэлээр судалгаа хийж, санал боловсруулж батлуулах</p> <p>Дотоодод үйлдвэрлэх боломжгүй 21 чиглэлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн татвараас чөлөөлүүлэх асуудлыг Засгийн газрын 168 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Уг тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, хугацааг сунгах төслийг боловсруулж яамдаас санал авахаар хүргүүлэхэд, СЯ хугацааг сунгах боломжгүй гэсэн хариуг ирүүлсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ- 70 %</p> <p>Боловсруулах үйлдвэрүүдэд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг дэмжих, тоног төхөөрөмж худалдан авах болон эргэлтийн хөрөнгийн зориулалттай хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг бий болгох шийдвэрийн төсөл боловсруулах Санамж бичиг, гэрээ байгуулах.</p> <p>Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-ий Өвсний үндэс техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Японы Ямагүчи Сангёо ХК нь Монгол улсад шилдэг технологи нэвтрүүлэх, арьс ширэн бренд хөгжүүлэх "MONY" төсөл дээр хамтран ажиллахаар Мон Ирээдүй ХХК, Монгол шевро ХК-тай хамтын ажиллагааны санамж бичгийг 2019.04.18-ны өдөр байгуулав.</p> <p>АХБ-ны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төслөөс үйлдвэрүүдэд тоног төхөөрөмж, хүчин чадлаа нэсэгдүүлэх, түүхий эд бэлтгэхэд 2018 онд 8.7, 2019 онд 9.6 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлснээр нэмүү өртөг шингэсэн болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ өссөн, шинээр самнах машины тоо, хүчин чадал өсч, ээрэх үйлдвэрүүд баригдаж зарим хэсэг цех нь ашиглалтад орсон байна. Эдгээр зээл авсан үйлдвэрүүдэд байгаль орчны үнэлгээ хийгдсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p> <p>Оюуны өмч ирээдүйн бүтээгдэхүүнээр барьцаалан зээл авах боломжийг судлан хэрэгжүүлэх</p> <p style="text-align: right;">ХШҮ-0%</p> <p>Гадаад худалдааны эрсдлээс хамгаалах даатгалын тогтолцоог нэвтрүүлэх боломжийг судлах</p> <p>Нарийвчилсан тооцоолол болон Засгийн газрын баримталж буй бодлогод үндэслэн хоёр хувилбарыг харьцуулж үзсэний үр дүнд Сангийн яам зээлийн даатгалыг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-д даатгаж, шууд бус үйлчилгээ үзүүлэх нь оновчтой гэсэн шийдвэрт хүрсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40%</p> <p>1.12 "Монгол экспорт" хөтөлбөрийн төсөл боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах</p> <p>Монгол экспорт хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, хөтөлбөрийг Засгийн газрын 2018 оны 278 дугаар тогтоолоор батлуулсан. Экспортыг дэмжих үндэсний зөвлөл байгуулах шийдвэр гарсны Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 37 дугаар захирамжаар “Экспортыг дэмжих зөвлөл”-ийг байгуулж, бүрэлдэхүүнийг баталсан. Зөвлөлийн орлогч даргаар ХХААХҮ-ийн дэд сайд томилогдож, анхдугаар хуралдааныг 2019.06.25-ны өдөр хийж Зөвлөлийн ажиллах журам, Монгол экспорт хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын мэдээлэл зэрэг хэд хэдэн асуудал хэлэлцэж шийдвэр гаргав.</p> <p>Хөтөлбөрийн хүрээнд АНУ, Канад, ОХУ-ын Улаан-Үүд, БНХАУ-ын Хөх хот, Улаанцав. Тинглоу хотод үзэсгэлэн худалдаа, өндөр дээд хэмжээний айлчлалын үеэр БНЭ, Сингапур, БНКаз.Улс, ОХУ-д бизнес форум зохион байгуулав. Улаанбаатар хотод “Монголын хаан ширхэгт”, Экспорт Монгол -2019 олон улсын форум, үзэсгэлэн худалдаа зохион байгуулахад хамтарч ажиллав.</p> <p>Уул уурхайн бус экспортлогчдыг дэмжих, урамшуулах, бүтээгдэхүүний сурталчилгааг нэмэгдүүлэхэд “Экспортлогчдын тэмдэглэлт өдөр”-ийг бий болгох зорилгоор ЗГ-ын шийдвэрийн төсөл боловсруулж, яамдын саналыг авч хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-г хүргүүлээд байна.</p>
--	--

	<p>Уул уурхайн бус экспортын хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалтын үр дүнгээр бий болсон нааштай эхлэл, үр дүнг тогтвортой хадгалж, өсгөн нэмэгдүүлэх зорилгоор ГХЯ, ХХААХҮЯ хооронд 2019-2020 онд хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөөг сайд нараар батлуулан хэрэгжүүлж байна.</p> <p style="text-align: center;">ХШҮ-100%</p> <p>Үйлдвэрлэлийг дэмжих сангийн үйл ажиллагааг салбарын хөгжлийн бодлоготой уялдуулах, сангийн тогтвортой эх үүсвэрийг төсвийн хуульд тусган бүрдүүлэх арга хэмжээг авах</p> <p>2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 87 дугаар тогтоолоор “Үйлдвэрлэлийг дэмжих сан”-г татан буулгасан. Уг тогтоолын дагуу ЗГ-ын тусгай сангийн тухай хууль болон боловсруулахыг холбогдох ЗГ-ын гишүүдэд даалгасан. ЗГ-ын тусгай сангийн тухай хууль (шинэчилсэн найруулга) -ийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсны үндсэн дээр үзэл баримтлалын төслийг боловсруулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу хянуулан батлуулахаар судалгааны тайлан, үзэл баримтлалын төслийг СЯ боловсруулан яамдаас санал авч нэгтгэж байна.</p> <p>Монгол Улсын Их хурлын 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 37 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 4.6 дахь хэсэгт “Ноолуур” хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүгийн хөнгөлөлтөд 22.6 тэрбум төгрөгийг тусгуулсан боловч СЯ-ны баталсан 2019 оны төсөвт тусгагдаагүй болно.</p> <p style="text-align: center;">ХШҮ-70%</p> <p>НӨАТ болон импортын гаалийн татварт нэмэлт, өөрчлөлт оруулах барааны жагсаалтыг аргачлалын дагуу боловсруулах</p> <p>СЯ-наас 168 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, хугацааг сунгах боломжгүй гэсэн хариуг өгсөн.</p> <p style="text-align: center;">ХШҮ-40%</p> <p>Татварын багц хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах</p> <p>Татварын хуулийн шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлснээр нэг талаас жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, бизнесийн орчныг сайжруулах замаар, нөгөө талаас татвараас зайлсхийх, зугтах явдлын эсрэг олон улсын туршлагаудыг нэвтрүүлэх замаар татварын бааз суурийг өргөжүүлнэ. Татварын ерөнхий хуулинд нэмэлт өөрчлөлт оруулан шинэчилсэн найруулгыг 2019 оны 3 сарын 22-нд УИХ-аас батлан гаргасан.</p> <p style="text-align: center;">ХШҮ-100%</p> <p>Салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх, хүрээлэнгүүдийн чадавхийг бэхжүүлэх,</p> <p>ЗГ-ын 2019 оны 370 дугаар тогтоолоор Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци /Армоно/ ТӨААТҮГ судалгааны байгууллагыг тус яамны харьяанд шилжүүлсэн.</p> <p style="text-align: center;">ХШҮ-100%</p> <p>ЗГ-ын 2015 оны 336-р тогтоолоор баталсан дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах</p> <p>ЗГ-ын “Жагсаалт батлах тухай” 90 дүгээр тогтоолоор “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт”-ыг нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн баталсан.</p> <p>Тогтоолоор 14 бүлгийн 175 нэр төрлийн бүтээгдэхүүнийг нэгтгэн батлуулсан.</p> <p style="text-align: center;">ХШҮ-100%</p> <p>"Ерөнхий гэрээ байгуулах журам"-н дагуу ерөнхий гэрээнд хамруулах бараа үйлчилгээний судалгааг хийж, цахим дэлгүүрийн санд байршуулах</p> <p>Төрийн худалдан авалтад нийлүүлдэг гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг Ерөнхий гэрээнд хамруулах судалгааг хийж, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль 2019 оны 5-р сарын 30-ны өдөр батлагдсантай холбогдуулан хүнсний худалдан авалтыг "Ерөнхий гэрээ байгуулах журам"-ын дагуу хийхээр шийдвэрлэсэн.</p> <p>Сангийн яамнаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.5.7-д заасны дагуу ерөнхий гэрээнд хамруулах бараа, ажил, үйлчилгээг тодорхойлох зорилгоор судалгааны ажлыг хийж байна. Судалгааны ажлын хүрээнд ерөнхий гэрээнд хамруулах барааны зах зээл, эрэлт, нийлүүлэлтийн судалгаа, шинжилгээг хийхээр төлөвлөсөн.</p> <p style="text-align: center;">ХШҮ-70%</p> <p>.Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгохтой холбоотой журмыг шинэчлэн баталж мөрдүүлэх</p>
--	---

		<p>Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журмын төслийг УУХҮЯ-тай хамтран боловсруулахад ажиллаж байна.</p> <p>Ноос, ноолуурын үйлдвэрүүдэд техник, технологийн түвшний үнэлгээ хийх нээлттэй тендерт “Монголын ноос, ноолуурын холбоо” шалгарч, үнэлгээний багийн тайланг хүлээн авав.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40%</p> <p>Стратегийн хүнсэн дэх тарифын бус хязгаарлалтыг олон улсын жишигт хүргэх, холбогдох журамд өөрчлөлт оруулах; 3Г-ын 2013 оны 77 дугаар тогтоолоор баталсан "Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журам"-ыг шинэчлэн боловсруулж 2019 оны 3Г-ын 329 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулан шинэчлэн батлуулсан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>Үйлдвэрийн техник, технологийн чиглэлээрх үндэсний стандартыг боловсронгуй болгох, олон улсын дэвшилтэт стандартуудыг нутагшуулан нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэх</p> <p>Модны -4, хэвлэлийн -2 сав баглааны -1, арьс ширний -5, оёдлын -3 нийт 16 стандарт боловсруулах ажилд зөвлөх үйлчилгээг зарлан мэргэжлийн холбоодоор гэрээгээр гүйцэтгүүлэн, дүгнэж, хөнгөн үйлдвэрийн салбарын худалдан авах ажиллагааны ажил хүлээн авах ажлын хэсгээр хүлээн авч, СХЗГ-ын салбар бүрийн Техникийн хороогоор хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Хэвлэл-2, сав баглааны 1, арьс ширний -1 стандартын төслийг СХЗГ-г хүргүүлэн батлуулсан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
<p>Зорилт 1-ийн дундаж үнэлгээ 73.3 хувь</p>		
	<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн : Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, түүхий эдийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх;</p>	<p>2.1 Түүхий эд бэлтгэх, хадгалах, чанарыг хамгаалах, тээвэрлэх үе шатанд мөрдөх стандарт, арга зүй, үнэ цэнийн сүлжээг бий болгох чиглэлээр сургалт явуулах; Баянхонгор аймагт АХБ-ны ХАА-н бүтээгдэхүүний НӨС-г дэмжих техник туслалцааны төслөөс 2019-10-04-ний өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан “Мал, мах, арьс ширэн түүхий эд бэлтгэл, анхан шатны боловсруулалт” сэдэвт технологийн сургалтад 8 сумын 14 -ийг, ШХА-ийн “Ногоон алт Малын эрүүл мэндийн эргэн мөшгөх систем” сургалтыг Богд, Жинст сумдад зохион байгуулж МЭТасаг, МЭҮН-ийн малын эмч нарт компьютер, махны антибиотикийн үлдэгдэл үзэх тоног төхөөрөмж олгосон.</p> <p>Говь-Алтай аймгийн Алтай Төгрөг, Бугат, Хөхморьт, Жаргалан сумдад малчдын зөвлөгөөн зохион байгуулж ноос ноолуур, арьс ширийг стандартын дагуу бэлтгэх талаар мэдээлэл хийж, технологийн талаарх богино видео хичээл үзүүлж 628 малчин хамруулав.</p> <p>Дархан-Уул аймагт мал амьтны гаралтай түүхий эд, бэлтгэх, нийлүүлэх худалдах үед тавигдах мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, стандарт мөрдөгдөх дүрэм, журмын талаар ХХААГ, МЭГ, СХХ-тэй хамтран 2100 гаруй хүнд 11 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Малчидтай уулзах уулзалтад оролцсон 100 гаруй малчид, мал бүхий этгээдэд ноос, ноолуур бэлтгэлийн видео хичээл үзүүлж түүхий эд бэлтгэлийн явцад чанарын хамгаалалт хийх, тухай зөвлөгөө өгөв.</p> <p>Завхан аймагт АХБ-ны ХАА-н бүтээгдэхүүний НӨС нэмэлт санхүүжилт төсөлтэй хамтран “Түүхий эдэд тордолт хийх, түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгоход шаардагдах технологи” –ийн сургалтыг Отгон, Дөрвөлжин, Эрдэнэхайрхан, Их-Уул сумдад зохион байгуулж, Малчид, хоршоо, хувийн мал эмнэлэг, хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүд нийт 80 хүн хамрагдлаа.</p> <p>Хөвсгөл аймагт “Түүхий эдэд тордолт хийх түүхийн эдийн тогтолцоог боловсронгуй болгоход шаардагдах технологийн сургалт”-ыг Улаан Уул, Алаг-Эрдэнэ, Арбулаг сумдад зохион байгуулан 60 хүнийг хамруулсан. ХААХХөгжил төслөөс 2019 онд НӨС-г хөгжүүлэх зээл олгох чиглэлээр 3261 хүн, Малчид, фермерүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр 1171 хүн, ААН-дийн маркетинг, техникийн хүчин чадал, чадамжийг сайжруулах чиглэлээр 913 хүн, Монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэлт чиглэлээр 351 хүн, Төслийн удирдлагын чиглэлээр 15 хүнийг тус тус сургалтад хамруулж нийт 1763 ажлын байр бий болсон. НҮБ-ын “Монгол Улсад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн хүрээнд “Арьс шир боловсруулах технологи”, “Хонины ноосыг машинаар хяргахад бэлтгэх нь”, “Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь”, “Хүхэрт устөрөгчийн хийтэй хэрхэн харьцах вэ”, “Гутлын зохион бүтээлт”, “Ажлын байр-цахим хосолсон сургалтыг хэрхэн зохион байгуулах, удирдах” зэрэг сургалтын хөтөлбөрүүдээр нийт 39 удаагийн сургалтыг 1600 гаруй хүнд хийж 10 гаруй сургалтын гарын авлага, товхимол боловсруулаад байна. Үүний үр дүнд сургалтад хамрагдсан хүмүүс мэргэжлийн ур чадвар, мэдлэгээ олон улсын сайн туршлагаар баяжуулж ажлын байрандаа эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг мөрдөн аливаа эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвартай болов. Түүнчлэн мэргэжлийн сэдвүүдээр бие даан сургалт зохион байгуулж хүний нөөцийг чадваржуулах нөхцөл бүрдлээ.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>

	<p>Орон нутагт түүхий эдийн гарал үүслийг баталгаажуулах лабораторийн чадавхийг сайжруулах</p> <p>Архангай аймгийн Мал эмнэлгийн лаборатори нь орчин үеийн дэвшилтэт техник, шинжилгээний багаж тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан. Явуулын иж бүрэн лаборатори болон полимариазын гинжин урвалын дэвшилтэд технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Мал эмнэлгийн барилгыг 2019 онд улсын төсвийн хөрөнгөөр шинээр байгуулах ажил 60%-тай байна.</p> <p>Лабораторийн сүлжээ цахим программ /www.vet.shinjilgee.mn/ 2016 оноос эхлэн бүх аймгуудад нэвтрүүлж, нийслэл болон бусад аймгуудын лабораториос малын өвчний оношлогоо, шинжилгээ түүхий эдийн гарал үүслийн шинжилгээг баталгаажуулан нэгдсэн мэдээлэлд оруулах нөхцөл бүрдүүлэв. ШХА-аас хэрэгжүүлсэн Ногоон алт-малын эрүүл мэнд төсөлд хамрагдсан Архангай, Говь-Алтай, Ховд, Завхан, Хөвсгөл, Төв зэрэг 6 аймгийн 15 сумын мал эмнэлгийн тасаг, нэгжийг дээрх цахим мэдээллийн системд холбох, мах, махан, сүү сүүн бүтээгдэхүүнд малын эмийн үлдэгдлийн шинжилгээ зөөврийн багаж, урвалж бодис нийлүүлж, эмч нарт ажлын байрны сургалт явуулав. Түүнчлэн мал, малын түүхий эдийн гарал үүслийг тодорхой болгох нэгдсэн бүртгэлд оруулах цахим технологи нэвтрүүлэх туршилт судалгааны ажлыг амжилттай гүйцэтгэв.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p> <p>2.3 Малын гаралтай түүхий эдийн гарал үүслийг тодорхойлох, бүртгэх, хянах тогтолцоог бий болгох, /мэдээллийн нэгдсэн сан, цахим сүлжээтэй болсон байна./ “Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар”-ыг МЭЕГ-ын даргын 2018 оны А/54 дүгээр тушаалаар баталж, www.legalinfo.mn сайтад байршуулсан. МЭЕГ-ын 2019 оны 95 тоот албан бичгээр МХЕГ, ЦЕГ, аймаг, нийслэлийн МЭГ-т зааврыг хүргүүлж, 332 сум, 9 дүүргийн МЭТ-ийн эмч, МЭҮН-ийн эмч нарт танилцуулав. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөнийг хянах зорилгоор мал эмнэлгийн гэрчилгээний систем (МЭГС)-ийг улс орон даяар нэвтрүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулан МЭЕГ-ын даргаар батлуулж, 21 аймгийн МЭГ, 332 сум, НМЭГ, 9 дүүргийн МЭТ, МЭҮН-ийн эмч нарт хүргүүлэв. ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ШХА-ийн Ногоон алт-Малын эрүүл мэнд төсөл, “Дижитал медик” ХХК-тай хамтран Мал эмнэлгийн нэгдсэн цахим системээр дамжуулан малын шилжилт хөдөлгөөнийг хянах ажлыг улс орон даяар нэвтрүүлэх сургалтыг бүх аймгийн МЭГ-ын холбогдох мэргэжилтнүүдэд ажлын байрны сургалтыг 2019 онд зохион байгуулсан. Аймгийн МЭГ-ын мэргэжилтнүүд сумдын МЭТ-ийн мэргэжилтнүүдэд цахим системийн сургалтыг хийсэн. 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тус цахим системд нийт 25500 гэрчилгээ бүртгэгдээд байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p> <p>2.4 Түүхий эд бэлтгэх, чанарын хамгаалалт, тордолт хийх төвийг малчдын бүлэг, хоршооны үйл ажиллагаатай уялдуулан сумдад байгуулах</p> <p>Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог сайжруулах, орон нутагт итгэмжлэгдсэн агуулахын үйл ажиллагааг эхлүүлэх, нэгдсэн мэдээллийн систем дээр тулгуурлан малчид, хоршоодын түүхий эдийг биржээр дамжуулан эцсийн худалдан авагч /үйлдвэр/-д шууд худалдах зорилгоор 57 хоршоонд биржийн итгэмжлэл олгож, зарим нь арилжаанд орж байна. Говь-Алтай, Архангай, Дорноговь, Завхан, Баянхонгор, Хөвсгөл аймгийн төвд хувийн хэвшилд тулгуурласан ложистикийн төвийг байгууллаа.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p> <p>2.5 Арьс ширийг хөдөө аж ахуйн биржээр арилжих талаар судалгаа тооцоолол хийх ЗГ-аас баталсан “Үйлдвэржилт 21:100”, “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрүүдийг үндэслэн “Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, мөшгөх тогтолцоо” арга хэмжээг ХХААХҮЯ, НЗДТГ, МЭЕГ, МХЕГ, аймгийн ЗДТГ, ХААБирж, МХААХҮХолбоо, ОУ-ын байгууллагуудтай /ADB, UNIDO, ШХА/ хамтран хэрэгжүүлж байна. Уг арга хэмжээний хүрээнд ХААБирж, малчид, хоршоодын мах, арьс, ширийг дотоодын үйлдвэрүүдэд форвард гэрээний арилжаагаар нийлүүлэх, дотоодын үйлдвэрийн махыг худалдааны байгууллагуудад, арьс, ширийг боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх ажлыг зохион байгуулна. Бирж нь малын гоц халдварт өвчингүй, эрүүл бүсээс мал эмнэлгийн үйлчилгээнд бүрэн хамрагдсан, эмийн үлдэгдэлгүй малын махыг хүнсний хэрэгцээнд нийлүүлэх, малын амьдын болон нядалгааны үеийн гэмтэлгүй арьс ширийг боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх, форвард гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. Бирж нь дээрх арга хэмжээний ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <p>2018 оны 11 дүгээр сарын 1-нд Форвард гэрээний нээлтийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, оролцогч байгууллагууд санамж бичиг болон форвард гэрээнд гарын үсэг зурсан. Форвард 6 гэрээ хийгдсэнээс махны гэрээ-4, арьс ширний гэрээ-1, амьд малын гэрээ-1 байна. Санамж бичиг 7 хийгдсэнээс махны-2, арьс, ширний-3, амьд малын санамж бичиг-2 хийгдсэн байна. Цаашид гэрээнд заагдсаны дагуу ажил үргэлжлэн явагдаж байгаа бөгөөд худалдах, худалдан авах гэрээнд хяналт тавин ажиллаж байна.</p>
--	---

		<p>Арга хэмжээнд оролцогч байгууллагуудыг бүртгэлжүүлэх, худалдах болон худалдан авах нэгдсэн захиалгын санг Биржийн www.mse.mn веб сайтад шинээр order-mse цэс нээж, уг цэсэнд мэдээлэл оруулах, захиалгыг шинэчлэх, гэрээний гүйцэтгэлийг хангуулах ажлуудыг хийж байна.</p> <p>Биржийн итгэмжлэгдсэн 58 хоршоо, “Ногоон алт” төсөлд хамрагдсан 89 хоршоо, нийт 147 хоршоодтой холбогдож мал, мах болон арьс шир нийлүүлэх тандалт судалгааг хийж гүйцэтгэсэн.</p> <p style="text-align: center;">ХШҮ-100%</p> <p>2.6 Хөдөө аж ахуйн биржээр хийх арьс ширний туршилтын арилжаа хийх ХААБ-ийн захирлын 2018 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн А/19 тоот тушаал, ЗГ-ын 2019 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 191 тоот тогтоолын хүрээнд “Их зам транс” ХХК, “Улаанбаатар мах экспо” ХХК, “New food century” ХХК-д агуулахын итгэмжлэл олгон биржийн Агуулахын бүртгэлийн програм суурилуулж, арилжаа төлбөр тооцооны санд бүртгэж, ажиллагааны зааварчилгаа өгөн туршилтын арилжааг эхлүүлсэн. 2019 оны 5 дугаар сарын 29-ны байдлаар 55,000 ширхэг стандартын шаардлага хангаагүй, боловсруулаагүй адууны ширийг биржийн арилжаагаар арилжиж, экспортолсон.</p> <p style="text-align: center;">ХШҮ-100%</p> <p>2.7 Малчдын хоршоо, боловсруулах үйлдвэрийн түүхий эд бэлтгэлийн агуулах, тоног төхөөрөмж сайжруулахад дэмжлэг үзүүлэх</p> <p>АХБ-ны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Жижиг хүнсний ногооны фермерүүдэд групп, нийгэмлэг үүсгэн хэрхэн үр ашигтай хамтран ажиллах боломжтой талаар сургалт зохион байгуулж, Борнуур, Орхон, Ерөө, Улаангом суманд ойролцоогоор 30 фермерүүдийн нийгэмлэг/групп байгуулах бөгөөд нэг группт 5-6 фермер гэр бүлийг оролцуулахаар төлөвлөж байна. Түүхий эдийг чанар, хадгалалт, хүлээн авалтыг сайжруулах зорилгоор ШХА-ын Ногоон алт-малын эрүүл мэнд төслийн 240 сая төгрөгийн санхүүжилтээр Өвөрхангай аймагт-3, Хөвсгөлд-3, Хэнтийд-1, Баян-Өлгийд-3, нийт 10 түүхий эдийн агуулахыг ашиглалтад оруулсан байна.</p> <p>АХБ-ны хөрөнгө оруулалтаар Архангай аймгийн Өндөр улаан суманд арьс ширэн түүхий эдийн анхан шатны тордолтын цехийг "Малчин түмний буя" хоршоог түшиглэн жишиг хоршоо байгуулахаар тоног төхөөрөмжийг суурилуулан, эхний хөрөнгө оруулалтаа хийсэн.</p> <p style="text-align: center;">ХШҮ-70%</p> <p>2.8 Алслагдсан бүс нутагт элеватор барих /Сэлэнгэ аймагт 13.0 мян. тн үр тариа хадгалах, 2.0 мян. тн үрийн буудай хадгалах цогцолбор барих/ 2018 онд ТЭДС-аас Сэлэнгэ аймгийн Шаамар суманд Дулаанхан тосгонд 2000 тн, Хөтөл салбарт 2000 тн багтаамжтай үрийн агуулах байгуулсан. ОХУ-ын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр 13.0 мян тн багтаамжтай элеватор байгуулахаар саналаа хүргүүлсэн. Эцэслэн шийдвэрлээгүй байна.</p> <p style="text-align: center;">ХШҮ-40%</p> <p>Төв, суурин газрыг түшиглэн зоорь, агуулах байгуулах.</p> <p>Улсын төсвийн хөрөнгөөр Ховд аймгийн Жаргалант суманд хүнсний ногооны 1000 тонн багтаамжтай хүнсний ногооны зоорь, Баян-Өлгий аймгийн Баяннуур сум, Сэлэнгэ аймгийн Жавхлант суманд 100 тонн багтаамжтай хүнсний ногооны зоорь байгуулсан. УБ хотод төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, махны хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулах ТЭЗҮ боловсруулсан.</p> <p>Хэнтий аймгийн Хэрлэн суманд Каритас чех ОУБ-ын 50.0 сая төгрөгийн санхүүжилтээр 70 тн багтаамжтай 2ш, Батноров суманд 10 тн, Өмнөдэлгэр суманд 60тн -ийн багтаамжтай зоорийг шинээр ашиглалтад оруулж, Цэнхэрмандал суманд 30тн багтаамжтай 1 зоорийг сэргээн засварлаж, Мөрөн сумын иргэд 30, 20 тн-ын багтаамжтай зоорь, Биндэр сумын ЗДТГ 50тн, нийт 390 тонн багтаамжтай 9 зоорь ашиглалтад оруулсан.</p> <p style="text-align: center;">ХШҮ-100%</p>
	Зорилт 2-ын дундаж үнэлгээ 80.0%	
3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх үйлдвэрүүдийг орон нутагт байгуулах, жижиг дунд		<p>3.1 Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг байгуулах</p> <p>Паркийн ТЭЗҮ, ХЕТ, дэд бүтцийн зураг төслийн ажил, инженер геологийн судалгааны ажил, түр цахилгаан хангамжийн бүтээн байгуулалтын ажлууд нийт 2,1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр тус тус хийгдсэн.</p> <p>ЗГ-ын 2017 оны 178 дугаар тогтоолоор Эмээлтийн “Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк”-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон.</p> <p>Бүтээн байгуулалтын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэхээр ЗГ-ын 2018.03.27-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлээр өгөгдсөн чиглэлийн дагуу Төрийн өмчийн концессын жагсаалтад оруулах материалыг ҮХГ-т хүргүүлсэн. ҮХГ-аас 2019 оны 01/2256 албан бичгээр төрийн өмчийн концессийн жагсаалтад тусгагдаагүй тул санхүүжилтийг бусад хэлбэрээр хэрэгжүүлэх нь нээлттэй гэж мэдэгдсэн.</p>

<p>үйлдвэрийг кластераар хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн, өрсөлдөх чадвартай, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх:</p>	<p>НЗДТГ-ын 2019 оны А/962 дугаар захирамжаар Эмээлтийн Хөнгөн ҮТП-ын ажлыг эрчимжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг судлах ажлын хэсгийг байгуулсан. Дэлхийн банкаас тус паркийн магадлан судалгаа, хууль, эрх зүйн зохицуулалтын судалгаа, төслийн хэрэгжих боломж, үнэ цэнэ болон санхүүгийн дүн шинжилгээ хийхээр зөвлөх томилол ажиллахаар шийдвэрлэсэн. НЗД-ын 2019.12.05-ны өдрийн А/1285 дугаар захирамжаар Паркийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, төслийн магадлан шинжилгээ хийх худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркт шилжүүлэн 2020 оны нийслэлийн төсөвт тусгаад байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40%</p> <p>3.2 Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барьж байгуулах Засгийн газрын 2017 оны 178 дугаар тогтоолоор Налайхын “Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк”-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон. Паркийн бүтээн байгуулалтад 2014-2018 онд нийт 6.3 тэрбум төгрөгийг зарцуулж, дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:</p>		
	№	Хийгдсэн ажил	Санхүүжилт /тэрбум.төг/
	2015 онд		
	1	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө	1.35
	2	Усны нөөц тогтоох гидрогеологи ажил	
	3	Оффисын барилга /660 м2 /	
	4	110/10 квт-ын дэд станц, 10 квт-ын хувиарлах байгууламжийн ажлын зураг, төсөл	
	5	Техник, технологийн түвшний үнэлгээ	
	2016 онд		
	6	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ /5 төсөл/	0,802
	7	Сайжруулсан шороон зам /2км/	
	8	Гүний худаг 2 ш	
	9	Цахилгаан хангамж /10 кв-н ЦДАШ-6.3км, 0.4 кв-н ЦДАШ-1.8км	
	2017 онд		
	10	Паркийн дэд бүтцийн 8 зураг төсвийн ажил болон БОНУ хийгдсэн	1.12
11	Тусгай зөвшөөрөл авсан.		
2018 онд			
12	Паркийн үерийн хамгаалалтын барилга байгууламжийг барьж байгуулахад	1.3	
13	Замын бүтээн байгуулалтын ажилд	1.8	
	Нийт	6,3	
<p>ЗГ-ын 2011 оны 104 дүгээр тогтоолын “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу өндөр технологи нэвтрүүлсэн, байгаль орчинд ээлтэй 21 ААН-тэй үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулж 6 үйлдвэр бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлэн ажиллаж байна. Паркийн анхны нэгжээр орсон үйлдвэр “Пийс стийл групп” ХХК-д Налайх дүүргийн 28 иргэнийг ажиллуулж байна. Тайлант 2019 онд авто замыг барьж байгуулах 1.5 тэрбум төгрөгийн/НЗД-ын/ санхүүжилт шийдвэрлэгдэж, одоогоор авто замын зорчих хэсэг болон явган хүний замын бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 80 хувьтай хийгдсэн. Паркийн үндсэн цахилгаан хангамжийн эхний ээлжийн 110 кв-ын дэд станц, удирдлагын байрыг барих 1.0 тэрбум төгрөгийн сонгон шалгаруулалт 2019.06.14-ний өдөр зарлагдсан боловч тендер шалгаруулалтын хүчинтэй хугацаа дууссан учир дахин 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр тендер зарлагдан “Хасу эрчим” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын гүйцэтгэл 20 хувьтай. 2020 онд цахилгаан хангамж, цэвэрлэх байгууламж, авто замын бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна..</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p> <p>3.3 Ховдын цэвэрлэх байгууламжийг байгуулах Арьс, шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн хоногт 8000м3 ус үйлдвэрлэх, арьс шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн үйлдвэр 11,8 тэрбум төгрөгөөр төлөвлөн түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр тендер зарлан “Саруул цамхаг” ХХК шалгарч зураг төслийг боловсруулан бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн. 2019 онд уг цэвэрлэх байгууламжийн санхүүжилтэд 2,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төсөвлөснөөс барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хүлээн авч, 1.01 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдоод байна. Нийт ажлын бүтээн байгуулалт 2019 оны байдлаар 70 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p> <p>3.4 Багануурын үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг байгуулах. Барилга, хот байгуулалтын сайдын багцаас 789.8 сая төгрөгийн санхүүжилтийг 2017 онд шийдвэрлэж хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон дэд бүтцийн зураг төслийн</p>			

	<p>ажлыг гүйцэтгүүлэн НИТХТ-ийн 2019 оны 130 дугаар тогтоолоор Паркийн Хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөг батлуулсан. Паркийн дэд бүтцийн зураг төсөл хүлээн авахтай холбогдуулан дулаан болон цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг Эрчим хүчний яамнаас олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/619 дүгээр захирамжаар Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, паркийн оффисын барилгын зураг төсөл хийлгэх 65 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдэн тендерийн сонгон шалгаруулалтын ажил хийгдэж, 2019 оны 12 дугаар сарын байдлаар паркийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээг боловсруулах ажлыг “Санни Трейд” ХХК нь 51 хувийн гүйцэтгэлтэй гүйцэтгэж байна.</p> <p>Мөн паркийн оффисын барилгын зураг төслийн гүйцэтгэгчээр “Нутаг консалтинг” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Паркийн оффисын барилгын зураг төслийн гүйцэтгэл 15 хувьтай.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40%</p> <p>3.5.Хөтөлбөрийн баримт бичигт байгаль орчны стратегийн үнэлгээ хийлгэх, байгаль хамгаалах ногоон хөгжлийн зорилтыг хангах, нөлөөлөлд өртөх байгалийн нөөц, экосистем, хүн амын эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл сөрөг нөлөөллийг тодорхойлох</p> <p>“Багануур үйлдвэрлэл, технологийн парк”-ийн техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нарийвчилсан үнэлгээг улсын төсвийн 300,0 сая төгрөгийн санхүүжилтээр хийгдсэн. 2019 онд байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, төслийн магадлан шинжилгээний үнэлгээний ажлыг нийслэлийн төсөв 400,0 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40%</p> <p>3.6 Орон нутгийн онцлог, нөөцөд суурилан дэвшилтэт технологитой, өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийн ТЭЗҮ, зураг төсвийг хийх.</p> <p>Хүнсний эслэг ихээр агуулсан жимсний хальс, навч, хүнсний ногоо, ургамал, жимс жимсгэнэ зэрэг эх орны түүхий эдийн шинэ нөөц ашиглан хийх "Эрүүл мэндэд чиглэсэн импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл" зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт зохион байгуулж, ТЭЗҮ-ийг боловсруулсан. Уг тайланд эрүүл мэндэд чиглэсэн найрлага бүхий эх орны түүхий эдийн шинэ нөөц ашиглалт, технологийн тооцоо, үйлдвэрийн зардал, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын тооцоо, тоног төхөөрөмжийн байршлын болон ерөнхий төлөвлөлтийн зураг зэргийг тусгасан бөгөөд энэхүү жишиг ТЭЗҮ-ийн дагуу ундаа, шүүсний үйлдвэр байгуулах боломж бүрдсэн.</p> <p>Ингэний сүү боловсруулах үйлдвэрийн байршил, газар, дэд бүтцийг шийдвэрлүүлж, үйлдвэрийн зураг төсвийн ТЭЗҮ-ийг "Монгол тэмээ корпораци" ХХК-иар орон нутгийн төсвөөр гүйцэтгүүлсэн.</p> <p>"Хүүхдийн сүүний үйлдвэр байгуулах" зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт зохион байгуулж, ТЭЗҮ-ийг боловсруулсан. "Цэвэр өсгөврийн хөрөнгө үйлдвэрлэх" зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт зохион байгуулж, ТЭЗҮ-ийг боловсруулсан. ТЭЗҮ боловсруулснаар үйлдвэр байгуулах зардал, технологийн тооцоо, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын тооцоо, тоног төхөөрөмжийн тооцоо, байршлын болон ерөнхий төлөвлөлтийн зураг зэргийг тусгаснаар үйлдвэр байгуулах боломж бүрдсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>3.7 Орон нутаг, нийслэлд 100-аас доошгүй үйлдвэрийг шинээр барьж байгуулах, шинэчлэхэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх</p> <p>ЗГ-ын 2018 оны 36 дугаар тогтоолоор батласан “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн эхний үе шатанд</p> <p>Бүтээн байгуулалтын ажил 100 хувь хийгдэж шинээр бүрэн ашиглалтад орсон 42 үйлдвэр, бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаа 19 үйлдвэр, хөтөлбөрийн 5.4-т “Хөтөлбөр хэрэгжих явцад улсын болон орон нутгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын орчин зэргээс шалтгаалан үр ашиг, ач холбогдол бүхий шинээр байгуулсан үйлдвэрийг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйлдвэрийн тоонд тооцож болно” гэж заасны дагуу ЖДҮХС, ОНХС, гадны хөрөнгө оруулалтаар 11 үйлдвэр, нийт 72 үйлдвэр 2018-2019 онд байгуулагдсан байна.</p> <p>Тус 72 үйлдвэрийг задлан харуулбал: УБ хотод 5, орон нутагт 67 үйлдвэр /2017 онд 2, 2018 онд 22, 2019 онд 48 / шинээр болон үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна.</p> <p>ЖДҮХС-ийн 3.5 тэрбум төгрөгийн зээлээр 35 үйлдвэр, 34 орчим тэрбум төгрөгийн хувийн хөрөнгө оруулалтаар 26 үйлдвэр, 55 орчим тэрбум төгрөгийн гадаадын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар 11 үйлдвэр тус тус байгуулагдаж, нийт 93 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тус тус хийгдсэн байна.</p> <p>Хөтөлбөрийн үр дүнд: Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 12 хувь, арьс, ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 40 хувь, ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 25.2 хувь, шинээр 72 үйлдвэр байгуулагдаж 4000 орчим ажлын байр бий болсон байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p>
--	---

	<p>3.8. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа, технологийн шинэчлэл хийсэн үндэсний үйлдвэрийн судалгааг хийх.</p> <p>ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А-575 тоот тушаалаар ноос ноолуурын салбарт Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортод гаргаж буй үйлдвэр, аж ахуй нэгжийн судалгааг, технологийн түвшний нарийвчилсан үнэлгээ хийлгэх судалгааг зөвлөх үйлчилгээгээр ТБОНӨХБАҮХАТ хуульд нийцүүлэн "Монголын ноос, ноолуурын холбоо" ТББ-аар гүйцэтгүүлэн ажлыг хүлээн авсан. Ноос, ноолуурын салбарт тогтвортой үйл ажиллагаа явуулж буй 203 аж ахуйн нэгж байна. Үүнээс 36 нь экспортод бүтээгдэхүүнээ гаргаж байгаа бөгөөд 28 нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30%-аас дээш хувийг экспортод гаргаж байна.</p> <p>ГЕГ: 2018-2019 оны эхний 11 сарын байдлаар ашигт малтмал болон түүхий эдээс бусад экспортод гаргаж байгаа, бараа бүтээгдэхүүний судалгааг гарган харьцуулан харахад :</p> <p>2018 онд нийт 793 аж ахуйн нэгж 792.5 сая.ам.долларын бараа, бүтээгдэхүүнд экспортын гаалийн бүрдүүлэлт хийгдсэн байна.</p> <p>2019 онд нийт 722 аж ахуйн нэгж 727.8 сая.ам.долларын бараа, бүтээгдэхүүнд экспортын гаалийн бүрдүүлэлт хийгдсэн байна.</p> <p>Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортлож буй ААН-үүдийн ихэнх хувийг ноос, ноолуурын үйлдвэрүүд эзэлж, "АПУ" ХХК болон "Жем-Интернэшнл" ХХК согтууруулах ундаа, "Жемхужирт" ХХК ус рашаан, "Монголтамхисо" ХХК ГХО янжуур тамхи, 28 аж ахуйн нэгж гоо сайхны болон ариун цэврийн ахуйн хэрэгсэл үйлдвэрлэсэн байна. Мөн 22 ААН савхин болон нэхий эдлэл, 56 ААН монгол гэр болон мод, модон эдлэл, 24 ААН хэвлэлийн үйлдвэр ном товхимол, 21 ААН бэлэг дурсгалын зүйлс тус тус үйлдвэрлэж бүтээгдэхүүнээ экспортод гаргасан байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>3.9 Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа үйлдвэрүүдэд олгосон зээлийн хүүгийн зөрүүг олгох ажлыг зохион байгуулах.</p> <p>Ноос, ноолуурын боловсруулах үйлдвэрүүдээс үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа 28 ААН-ийн технологийн шинэчлэл хийсэн хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгөд зориулан арилжааны банкнаас олгосон зээлийн хүүг 7% хувьд шилжүүлж тооцоход зээлийн хүүгий зөрүү 10,019.9 сая төгрөг болж байгааг судалгаагаар гаргасан.</p> <p>2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 87 дугаар тогтоолоор "Үйлдвэрлэлийг дэмжих сан"-г татан буулгасан, мөн 2019 оны 11 дүгээр сарын 13 өдөр "Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай" хууль батлагдсанаар хэрэгжүүлэх боломжгүй болсон.</p> <p style="text-align: right;">ХШҮ- ҮБ-гүй</p> <p>3.10 Өндөр үр ашиг бүхий дэвшилтэт технологи болон өндөр технологи бий болгон нэвтрүүлж нутагшуулсан экспортын үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжүүдийн судалгааг гаргах</p> <p>Өндөр үр ашиг бүхий дэвшилтэт технологи болон өндөр технологи бий болгон нэвтрүүлж нутагшуулсан экспортын үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжүүдийн судалгааг гаргасан.</p> <p style="text-align: right;">ХШҮ- 40%</p> <p>3.11 Үйлдвэржилтийн тухай хуулийн дагуу судалгаа, хөгжилд зарцуулсан зардлын 75 хүртэлх хувьтай тэнцэх дэмжлэгийг нэг удаа улсын төсвөөс тухайн үйлдвэрт буцааж олгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох</p> <p>2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 87 дугаар тогтоолоор "Үйлдвэрлэлийг дэмжих сан"-г татан буулгасан, мөн 2019 оны 11 дүгээр сарын 13 өдөр "Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай" хууль батлагдсанаар хэрэгжүүлэх боломжгүй болсон.</p> <p style="text-align: right;">ХШҮ-ҮБ-гүй</p> <p>3.12 Салбарын хөгжил, нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий шинжлэх ухаан, технологийн болон инновацийн төслүүдийн үр дүнг үйлдвэрлэгчдэд мэдээлэх, түгээх</p> <p>Инновацийн соёлыг төлөвшүүлж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, инновацийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Инновацийн 7 хоног-2019" арга хэмжээг 2019.05.06-12-ны өдрүүдэд ҮБ хотод зохион байгуулав. "Хамтын инноваци" уриатайгаар Инновацийн үйл ажиллагаа, хууль, эрх зүй, төрийн бодлого, төр, хувийн хэвшил, их, дээд сургууль, ЭШБ-ын шинжлэх ухаан, технологи, инновацийн хамтын ажиллагаа, түншлэлийн боломжууд нээх, олон нийтэд инновацийн бүтээгдэхүүнийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор БСШУСЯ, ҮХГ, НШУҮИГ, ОӨГ, ШУТС, ШУА, ШУТИС, СУИС, ХААИС, БХИС, МУИС, АШУҮИС, МУБИС, МҮХАҮТ, Монголын залуу эрдэмтдийн холбоо ТББ, Монголын хамтын оффисын холбоо ТББ зэрэг байгууллагууд хамтран зохион байгуулав. "Инновацийн 7 хоног -2019" арга хэмжээний хүрээнд "Хамтын инноваци-2019" хэлэлцүүлэг, "Инновацийн</p>
--	--

	<p>үзэсгэлэн-2019”, залуу судлаачдын “ВРА-2019”, “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-2019”, “ICIED-2019 ЭШ-ний бага хурал, “Соёлын арга хэмжээний хаалтын ажиллагаа”, “Инновацийн хөгжил-хамтын ажиллагаа” уулзалт хаалтын ажиллагааг зохион байгуулав.</p> <p style="text-align: center;">ХШҮ-100%</p> <p>3.13 Инновацийг дэмжиж үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудтай хамтран ажиллах. Хүнсний аюулгүй байдлыг хангахад оюутан, судлаач, эрдэм шинжилгээний ажилтны оруулах хувь нэмрийг зохих ёсоор үнэлэх, эрдэм шинжилгээ, судалгааны дүнг төрийн бодлого, шийдвэрт тусган хэрэгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх, төрийн захиргааны болон эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлэх, хүнсний салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, олон нийтэд сурталчлан таниулах, хүнсний салбарын боловсон хүчнийг бодлогын түвшинд бэлтгэх, салбар дундын уялдааг хангах зорилгоор "Хүнсний аюулгүй байдал" ЭШ-ний бага хурлыг Дэлхийн хүнсний өдрийг тохиолдуулан жил бүр уламжлан зохион байгуулж байна. Инновацийн соёлыг төлөвшүүлж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, инновацийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг.</p> <p style="text-align: center;">ХШҮ-100%</p> <p>3.14 Хэвлэлийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний төв байгуулах. Санхүүжилтын асуудал шийдэгдээгүйгээс төв байгуулах боломжгүй.</p> <p style="text-align: center;">ХШҮ-ҮБ%</p> <p>3.15 Арьс ширний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, технологи дамжуулах төв байгуулах. Арьс ширний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, технологи дамжуулах төв байгуулах Засгийн газрын 2019 оны 370 дугаар тогтоолоор “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг ХХААХҮЯ-ны харьяа болгосон. Тус байгууллагыг арьс ширний үйлдвэрийн салбарын технологи, инноваци дамжуулах төв байхаар хэтийн төлөвийг тодорхойлж ТЭЗҮ-г боловсруулаад байна.</p> <p style="text-align: center;">ХШҮ-40%</p> <p>3.16 Мебель модон бүтээгдэхүүнийг турших лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх БСШУСЯ-нд хүсэлт явуулсан боловч санхүүжилтын асуудлыг шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу өгсөн.</p> <p style="text-align: center;">ХШҮ-ҮБ%</p> <p>3.17 Франчайзинг нэвтрүүлэх боломжтой сонирхогч салбар үйлдвэрийн судалгаа хийх. Монпеллетс” ХХК-ийн ахрын ноосоор хийсэн био бордоо, “Гарааны био ундарга” ХХК-ий “Ризо” шингэн бордоо, “Three flames” ХХК-ийн үйлдвэрлэсэн хадлан дээл нь дотоодын болон гадаадын орнуудад эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүний нэг болсон байна.</p> <p style="text-align: center;">ХШҮ-40%</p> <p>3.18 Франчайзинг нэвтрүүлэх олон улсын зөвлөгөөнд оролцох, үйлдвэрлэлд нэвтрүүлэх инновацийг тодорхойлох, хэрэгжүүлж эхлэх Франчайзинг нэвтрүүлэх боломжтой, сонирхогч салбар, үйлдвэрийн судалгааны хүрээнд жил бүр зохион байгуулагддаг Олон улсын франчайзингийн олон улсын зөвлөгөөнд оролцсон. Франчайзинг нэвтрүүлэхээр Дархан -Уул аймгийн арьс ширний гүн боловсруулах, ноос ноолуурын зэрэг үйлдвэрүүдийг хөгжлийн загвар үйлдвэрт тодорхойлоод байна. Тус аймагт арьс ширний гүн боловсруулах хөгжлийн загвар франчайзинг үйлдвэр байгуулах чиглэлээр Европын Холбооны Улсын Бельги, Итали, Герман зэрэг улсын туршлага судлан үзэсгэлэнд оролцож энэ талаар Италийн арьс ширний АССОМАК холбоотой хамтран ажиллахаар тохиролцов. Монпеллетс” ХХК нь франчайзинг нэвтрүүлж монгол хурганы болон ахрын ноосоор био бордоо үйлдвэрлэн Берлин хотын Хумболдын Их сургуультай 2005-2007 онд хамтран технологи инновацийн бүтээгдэхүүн гаргасан. Төв аймгийн Эрдэнэ суманд орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж суурилуулж, үйлдвэрээ 2018 оны 9-р сард байгуулан, Герман Япон, Солонгос болон дотоодын зах зээлд нийлүүлж байна. Уг бордоо нь экологийн цэвэр бүтээгдэхүүнээс гадна ургацыг 2-3 дахин нэмэгдүүлдэг, баруун Европ, Азийн зарим оронд экспортод гардаг, зах зээлийн өндөр үр ашигтай инновацийн бүтээгдэхүүн болоод байна. Дараахь үйлдвэрүүд нь шинэ технологи нэвтрүүлж инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Үүнд: Уламжлалт үндэсний монгол дээлийг орчин үеийн нано технологиор гарган авсан гал болон ус нэвтэрдэггүй материалаар “Хадлан” дээлийг “Three flames” ХХК ны загвар зохион бүтээгчид бүтээн, инновацийн эрэлт өндөр бүтээгдэхүүн болоод байна. Дотоод зах зээлээс гадна АНУ, Герман, Францад эрэлттэй, борлуулалт өндөр бүтээгдэхүүн болсон. Дархан-Уул аймгийн УГТЭШХ-нд “Гарааны био ундарга” ХХК-ий “Ризо” шингэн бордооны үйлдвэр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэллээ. Шингэн</p>
--	--

		<p>бордооны хувьд ашиглаж, түгээхэд хялбар, үр дүн сайтай. Уг бордоог ашигласнаар үрт ургамлуудыг 10-20 хувь, төмсийг 15-25 хувь, улаан лооль, өргөст хэмх зэрэг нарийн ногоог 20-40 хувь хүртэл ургацыг нэмэгдүүлэх боломжтой. Энэхүү үйлдвэр нь жилдээ 300 тонн шингэн био бордоо үйлдвэрлэх хүчин чадалтай юм.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>3.19. Соёлын болон бүтээлч аж үйлдвэрлэлийн үзэсгэлэн зохион байгуулах, сурталчилгаа хийх, төрийн худалдан авалтаар дэмжих, төсөл боловсруулах. Инновацийн соёлыг төлөвшүүлж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор "Монголын инновацийн 7 хоног-2018" арга хэмжээг 2018 оны 5 дугаар сард зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд "Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын үеийн ба Монгол улсын хөгжлийн асуудлууд" болон "Соёлын бүтээлч үйлдвэрлэл-2018" Инновацийн үзэсгэлэн-2018" зэрэг томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. ЗГХА Соёл, урлагийн газраас зохион байгуулсан "Орчин үеийн соёлын илэрхийллийн олон төрөл болон бүтээлч үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих нь" Үндэсний зөвлөлдөх уулзалтад 2019 оны 05 дугаар сарын 09 ны өдөр оролцов. Уулзалтын үеэр соёлын болон бүтээлч үйлдвэрийн өнөөгийн нөхцөл байдал, Юнеско-ийн "Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхүүлэн дэмжих тухай 2005 оны конвенцийн үндсэн баримт бичгүүд" -тэй танилцан 4 салбар хуралдааны Соёлын болон бүтээлч үйлдвэрлэл ба жандер сэдэвт хэлэлцүүлэгт оролцон санал солилцов. Мөн Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, санхүүжүүлэх боломжууд, соёлын олон төрлийг дэмжих олон улсын сангийн тухай Юнеско-ийн Соёлын илэрхийллийн олон төрлийг дэмжих газрын Соёлын хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Рейко Ёшида танилцуулав. Уг ажлын хүрээнд соёлын газар болон бусад төлөөлөлтэй кино урлагийн салбарыг дэмжих, үндэсний үйлдвэрлэл, өв соёлыг түгээн сурталчилах талаар цаашдын үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллахаар санал солилцов.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p> <p>3.20. Үйлдвэрүүдэд үндэсний түүх, соёлын онцлогтой шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож сургалт зохион байгуулах Урбан брэндийн Хүрээ коллекц: Монголын нууц товчоонд гардаг Бөртэ чоно, Гоо маралын домгоос гадна ариун нандин хайрыг хаан бугуйвч, хатан сүйхээр төлөөдүүлэн, бат бэх, эрүүл энхийг ханан хээгээр бэлгэдэн, эрдэм ном, элбэг баяныг зоосон хээгээр загвартаа тусгалаа. Ингэснээр уламжлалт үндэсний хувцаснууд маань илүү загварлаг, трендлэг биед эвтэйхэн, таатай байдлыг бүрдүүлэх боломжтой болсон. "ХҮРЭЭ" брэндийн өдөр тутмын загварлаг Монгол цамцнуудыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн худалдаанд гаргав.Өдөр тутмын их хотын амьдралын хэмнэлд зориулан Хүрээ коллекцийн улирлын шинж чанартай байсан бүтээгдэхүүний цувралыг илүү өргөн хүрээтэй болгож Хүрээ брэндийг гаргасан. Ийнхүү үндэсний түүх, соёлын онцлогтой бүтээгдэхүүн үйлдвэрлэл хөгжиж байгааг бодлогын түвшин дэмжин 07 сард Үндэсний хувцасны үзэсгэлэн худалдаа, загварын шоу арга хэмжээг зохион байгуулахад мэргэжлийн холбоотой хамтран ажиллаж сурталчилах нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг хийсэн. Монголын соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх хүрээнд ХХААХҮЯны Хөнгөн үйлдвэрийн газраас монгол үндэсний хувцасны өдөрлөг, бүтээлч ажлын аяныг зохион байгуулав. Уг арга хэмжээний үеэр нийт ажилтан албан хаагчдын дунд "Дээлээрээ гоёцгооё" 7 хоног зохиож, мөн дээлээ өөрөө урлаж өмсдөг иргэнийг шалгаруулах, Шик салонтой хамтран загварын дээлний чиг хандлагын талаар лекц танилцуулга хийсэн. Үндэсний монгол дээлний өдөртэй болох тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан, яамдаас санал авч нэгтгэн хуралдаанаар оруулахад бэлэн болгосон. Монгол дээлийг инновацийн бүтээгдэхүүн болгож буй "Хадлан" дээлийн загварыг сурталчлан танилцуулж, гадаад зах зээлд үйлдвэрлэн гаргаж байна. Монгол уламжлалт гэрийн ерөнхий архитекторыг орчин үеийн майхан хэлбэрт оруулан инновацийн бүтээгдэхүүн болгон, гадаад зах зээлд дээр хөрөнгө оруулах маркетинг хийж, бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж буй ГЭР ТЕНД ХХК экспортын үйлдвэрлэл явуулж, гадаад орны захиалга авч үйлдвэрлэж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>3.21 Хөтөлбөрт тусгасан шинээр байгуулах, шинэчлэх үйлдвэрүүдийг эрчим хүчээр хангах судалгаа тооцоог хийх. Эрчим хүчний яам, Диспетчерийн үндэсний төвийн хүсэлтийн дагуу Хөнгөн үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй томоохон компаниудын нэр, байршил, улирлын чанартай ажиллах хугацаа, цахилгааны ачааллын мэдээллийг салбаруудаар гарган хүргүүлэв. Хэнтий аймгийн Баянхутаг, хөвсгөл аймгийн Галт сумдад барьж буй хуурай сүүний үйлдвэрүүдийн эрчим хүчний асуудлыг шийдвэрлэснээр үйлдвэр үйл ажиллагаагаа эхлэх боломж бүрдсэн. Мөн "Эмээлтийн үйлдвэр технологийн парк", "Налайхын Үйлдвэр технологийн парк"-д шаардагдах цахилгаан эрчим хүчний хангамжийг шийдвэрлэх зорилгоор тус паркийн ТЭЗҮ, урьдчилсан судалгаа, захиалагчийн хүсэлтийг харгалзан ЭХЯ-ны</p>
--	--	--

		<p>Техникийн нөхцөл олгох ажлын хэсгийн 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд 13С/2018/82 болон 65/2018/82 тоот техникийн нөхцлүүдийг олгосон. Ингэснээр тус паркийн цахилгаан эрчим хүчний дэд бүтцийн ажлыг эхлүүлэх боломжийг бүрдүүлж өгсөн.</p> <p>"Хөтөлбөрт тусгасан шинээр байгуулах, шинэчлэх үйлдвэрүүдийг эрчим хүчээр хангах судалгаа тооцоог хийх" ажлын хүрээнд тус яамнаас судалгаа мэдээлэл ирүүлэх албан бичиг боловсруулан 2019 оны 06 дугаар сарын 04-ий өдөр хүргүүлсэн. Судалгааны ажил хийгдэж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40%</p> <p>3.22. Эрчим хүчээр хангах бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхэд холбогдох яамтай хамтарч ажиллах.</p> <p>Эрчим хүчний яамнаас эрчим хүчээр хангагдахыг хүссэн үйлдвэрүүдийн цахилгаан хангамжийг цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний хүчин чадалд тулгуурлан зохих журмын дагуу шийдвэрлэн олгож байна. Нэгдсэн сүлжээнээс хэт алслагдсан уул уурхайн олборлох үйлдвэрүүдийн тухайн бие даасан эх үүсвэрээр шийдвэрлэхийг чиглэл болгож байна. Монгол Улсын нутаг дэвсгэрт өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэглээг бүрэн хангах хүрээнд дунд хугацааны зорилгод хөтөлбөрийг гарган хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2018 онд нэгдсэн системд 118МВт суурилагдсан чадал бүхий эрчим хүчний эх үүсвэрүүдийг ашиглалтад оруулсан. Ойрын хугацаанд Эрдэнэтийн ДЦС-ын 35МВт өргөтгөл, ДЦС-4-ийн турбогенераторуудын шинэчлэл 89 МВт, ДЦС-3-ийн өндөр даралтын хэсгийн хүчин чадлыг 75 МВт-аар нэмэгдүүлэх, Амгалангийн дулааны станцыг түшиглэн 50МВт-ийн цахилгаан дулаан хосолсон үйлдвэрлэх станц барих, Дорнодын ДЦС-ын 50 МВт-ийн өргөтгөл, 100 МВт-ын цэнэг хураагуур, дунд хугацаандаа ДЦС-3-ын 250 МВт-ын өргөтгөл, ДЦС-2-ийн 300 МВт-ыг өргөтгөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Бөөрөлжүүтийн цахилгаан станц, Багануурын цахилгаан станц, Алтай-Улиастайн эрчим хүчний систем, Баруун бүсийн эрчим хүчний эх үүсвэрийн төслүүд тэдгээрийг холбох цахилгаан дамжуулах шугмын төслүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
Зорилт 3-ийн дундаж үнэлгээ 70.0%		
	<p>4-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Боловсруулах үйлдвэрийн хөгжлийн чиг хандлага, эрэлтэд нийцүүлэн хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;</p>	<p>Хөнгөн, хүнсний салбарт хамаарах ажил мэргэжлийн нэршил, тэдгээрийн индекс кодыг шинэчлэх; БСШУС-ын сайдын 2016 оны А/150 дугаар тушаалыг шинэчлэн батлуулах бэлтгэл хангагдаж байна. Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагууд, мэргэжлийн холбоод, ажил олгогчдоос болон АХБ-ны "Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл"-өөс ирүүлсэн мэргэжлийн нэр, индексийг шинэчлэн тогтоох санал, хүсэлтийг тус тус судлан хэлэлцэж байна. АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлж буй "Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх" МОН-3243 төслийн хүрээнд Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудаар бэлтгэх мэргэжил/хөтөлбөрийн нэр индексийг Боловсролын Олон улсын стандарт, ангилалд нийцүүлэн шинэчлэх судалгааны ажил хийж, салбарын яамдууд, мэргэжлийн холбоод, хүсэлт гаргасан байгууллагуудад албан бичгээр хүргүүлж, санал авч нэгтгэх ажил хийгдэж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p> <p>Боловсруулах үйлдвэрийн салбарын ажиллах хүчийг бэлтгэх, сургах, давтан сургах арга хэмжээг МСҮТ-үүдийг түшиглэн зохион байгуулах Завхан аймгийн Политехникийн коллеж 2019 онд боловсруулах "С" ангиллын 10 гаруй төрлийн үйлдвэрлэлд мэргэшүүлэх сургалтад 700 гаруй оюутныг хамруулан зохион байгуулж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>"Мэргэжилтэй ажилтан" хөтөлбөрийг боловсруулах ажлыг "Ажилсаг Монгол" хөтөлбөртэй уялдуулан нэгтгэн зохион байгуулах. "Мэргэжлийн боловсрол, сургалт-Ажилсаг Монгол" үндэсний зөвлөгөөнийг Төрийн ордонд зохион байгуулж, Улсын их хурлын гишүүд, элчин сайд, Монголын ажил олгогч эздийн холбоо, МБСБ-ын захирал, багш, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдийн удирдлагууд, суралцагч, төгсөгчид, холбогдох төрийн болон ТББ-ын төлөөлөл нийт 850 хүн оролцуулав. Мэргэжилтэй ажилтан" хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ТНБД-ын А-507 тушаалаар шинэчлэн, ажлын хэсгийн төлөвлөгөө гаргаж батлуулсан. Хэвлэлийн салбарын эрдэмтэн судлаачидтай мэргэжлийн холбоо хамтран хэвлэгч-дэвтэрлэгчийн сургалтыг зохион байгуулж, 42 ажилтанг хамруулсан. Хөнгөн үйлдвэрийн 10 салбарт салбар бүрийн хүний нөөцийн асуудлаар тулгамдаж буй асуудал, гарц шийдэл хэлэлцүүлгийн 2019 оны 10-09-нөөс 10-25-ны хооронд хийж, зөвлөмжийн төсөл бэлтгэн Хөнгөн үйлдвэрийн улсын зөвлөгөөнөөр танилцуулсан. Хөнгөн үйлдвэрийн салбарын ИТА бэлтгэгч ШУТИС-ын БуХУС, УТС-тэй хамтран Хөнгөн үйлдвэрлэл хүний нөөц- тогтвортой хөгжил" онол практикийн бага хурлыг зохион байгуулж, их дээд сургуульд бэлтгэгдэж буй мэргэжилтний судалгаа,</p>

		<p>тогтвор суурьшилтай ажиллах боломж, үйлдвэрлэлийн мэргэжилтний эрэлт хэрэгцээ зэрэг 6 асуудал дэвшүүлсэн илтгэл тавьж, хэлэлцүүлэв.</p> <p>Мөн “Ноолуур” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн суурь судалгааг үндэслэн хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдлын судалгааг хийсэн. “Ажилсаг монгол” хөтөлбөртэй хөнгөн үйлдвэрийн салбарын хүний нөөцийн эрэлтийн судалгаа, асрамж халамжаас гарч буй залуусыг ажлын байраар хангах зорилгот төслийг хамран зохион байгуулах ажлыг төлөвлөв.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p> <p>4.4 Хөнгөн үйлдвэрийн салбарыг “Тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэл”-д оруулж, Засгийн газрын 2014 оны 71-р тогтоолд өөрчлөлт оруулах.</p> <p>ХХААХҮЯ ны ТНБД-ын 2019 он ы 05-13 ны 01/1866 албан бичгээр нэхмэлийн болон хөнгөн үйлвэрийн ашиглалтын технологи,хувцас үйлдвэрлэл, ойн инженер, хэвлэл, мод, эко материал боловсруулах 9 мэргэжлийг “тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрийн /мэргэжил/ жагсаалт”-д оруулах, элсэгчдийг тэтгэлэгт хамруулах тухай саналыг БСШУЯ-нд шийдвэрлүүлэхээр хүргүүлэв.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p> <p>4.5 Боловсруулах үйлдвэрийн удирдах болон инженер, техникийн ажилтнуудыг нарийн мэргэжлээр өндөр хөгжсөн оронд давтан сургах, туршлага судлуулах, чадавхижуулах, менежментийн болон технологийн сургалтыг зохион байгуулах.</p> <p>“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн дэмжлэгтэй Турк улсад зохион байгуулагдах “Техникийн текстилийн олон улсын сургалт, хурал”-д 4, БНХАУ-д гутлын үйлдвэрлэлийн чиглэлээр 6 хүнийг хамруулав. Техник Технологийн Дээд сургуулийн харьяа “Монгол Коосэн” Технологийн Коллежийн 10 оюутан Япон улсын үйлдвэр, компанид 1-4 долоо хоногийн дадлага хийж ирсэн. Дэлхийн банкны “Экспортыг дэмжих” төслийн санхүүжилтээр ШУТИС-ийн ҮТИС-ийн Шима Сейки сургалтын төвтэй хамтран Япон улсын Шима Сейки фирмийн сүлжмэлийн машины SDS-ONE APEX-3 дизайн системийн анхан шатны болон ахисан түвшний 2 удаагийн сургалтад ноос, ноолуурын үйлдвэрийн инженер, технологич, программист зэрэг 38 оролцогч хамрагдаж сүлжмэлийн SDS-ONE системийн тохиргоо, цэс, түүд, программ хангамжийн автомат тохиргоо, авто процессын параметрууд, оптик шугам, нэхэх, хянах симуляци, сүлжмэл эдлэл хийх, машин механизм, дэлгэцийн машин засвар үйлчилгээ, сүлжмэлийн программ, бүтцийг бэлтгэх зэрэг мэдлэг эзэмшлээ. Мөн төслийн санхүүжилтээр Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж байгаа 12 компанийн хүсэлтээр Штолл фирмийн Хятад дахь албан ёсны төлөөлөгчийн газрын ахлах сургагч багш Яан Зейлянг урьж, 10 өдрийн техникийн түвшний сургалт зохион байгууллаа. Сургалтад эдгээр компанийн машин баригч 12 ажилтан хамрагдаж CMS машины бүтэц зохион байгуулалт, сүлжих, нэхэх технологи, машинд шаардагдах төрөл бүрийн үйлчилгээ, программ хангамжийн асуудлаар онол, практик хосолсон мэдлэг ур чадвар эзэмшиж цаашид ажлын байран дээрээ сургагч багш болох зорилготой юм. Сургалтыг амжилттай төгссөн ажилтнуудад Германы Штолл фирмийн сургалтын гэрчилгээ олгосон.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>Боловсруулах үйлдвэрийн мэргэжлээр суралцаж байгаа оюутны сургалтын болон төгсөлтийн дадлагын хугацааг уртасгах, сургалт үйлдвэрлэлийн уялдааг хангах, дадлагын үр өгөөжийг дээшлүүлэх</p> <p>Боловсруулах үйлдвэрийн мэргэжлээр суралцаж байгаа оюутны нийт цаг 3380 байгаагийн үйлдвэр дээрх сургалтын дадлагын цаг 350 байсныг 720 цаг болгон уртасгав. Хөнгөн үйлдвэрийн салбарын ИТА бэлтгэгч ШУТИС-ын БуХУС, ҮТС-тэй хамтран “Хөнгөн үйлдвэрлэл хүний нөөц- тогтвортой хөгжил” онол практикийн бага хурлыг 2019.03.21-нд зохион байгуулж, их дээд сургуульд бэлтгэгдэж буй мэргэжилтний судалгаа, тогтвор суурьшилтай ажиллах боломж, үйлдвэрлэлийн мэргэжилтний эрэлт хэрэгцээ зэрэг 6 асуудал дэвшүүлсэн илтгэл тавьж, хэлэлцүүлсэн. ШУТИС-ын БуХУС дээр 2019 оны 4-р сард хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр суралцан төгсөгчдөд мэргэжил сурталчлах 7 хоног зохион байгуулж, ХХААХҮЯ-ны ХҮХБЗГ-ын мэргэжилтнүүд болон зарим компаний удирдлагууд оролцов. ҮТС, БуХУС-ын оюутнуудын үйлдвэрлэлийн дадлагын өгөөжийг дээшлүүлэх зорилгоор ноолуурын, арьс ширний 3 үйлдвэрт төгсөлтийн өмнөх дадлагыг 12 оюутан хийв. Хөнгөн үйлдвэрлэлийн менежментээр суралцагч 4 оюутнуудыг хөнгөн үйлдвэрийн хөгжлийн бодлого зохицуулалтын газарт танилцах дадлагыг хийлгэв.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p> <p>Үйлдвэрлэлийн дадлага хийх хугацаанд оюутан сурагчдын хөдөлмөрийг үнэлэх, цалин урамшууллын механизмыг бий болгох</p> <p>Мэргэжилтэй ажилтны эрэлт хэрэгцээг харгалзан үйлдвэр аж ахуйн нэгжүүд өөрсдийн санаачилгаар дараах ажлыг эхлүүлээд байна. Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэгч "Их газрын чулуу" ХХК “Нутгийн ирээдүй” оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг 2 чиглэлээр зарласан. Үүнд: 1. Дадлагажигч оюутны сарын тэтгэлэг /50 000₮/ 2. Тухайн мэргэжлээр суралцагчийн сургалтын төлбөрийн тэтгэлэг /2 сая төгөөг/ гэсэн 2 чиглэлээр уралдаан зарлаж шалгаруулан ажилласан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40%</p>
--	--	---

		<p>4.8 Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 5 -аас дээш жил ажиллаж буй их, дээд сургуульд элсүүлэн суралцуулах боломжтой нарийн мэргэжилтэй ажилтны судалгаа гаргах.</p> <p>Хөнгөн үйлдвэрийн салбарт 5-аас дээш жил ажиллаж буй мэргэжилтэй ажилтны урьдчилсан судалгааг гаргасан. Судалгаанд үндэслэн ШУТИС-ын УТС болон холбогдох бусад их дээд сургуульд түргэвчилсэн программаар суралцуулах боломжийн талаар салбар бүрийн хэлэлцүүлэг зохион байгуулав.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p> <p>Нарийн мэргэжлийн ажилтнуудыг их дээд сургуулиудад хөнгөвчилсөн, түргэвчилсэн хөтөлбөрөөр сургах.</p> <p>АХБ-ны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төслөөс 2019 оны 12 сарын 31-ний байдлаар Нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зээл олгох чиглэлээр 3261 хүн, Малчид, фермерүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр 1171 хүн, ААН-дийн маркетинг, техникийн хүчин чадал, чадамжийг сайжруулах чиглэлээр 913 хүн, Монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэлт чиглэлээр 351 хүн, Төслийн удирдлагын чиглэлээр 15 хүнийг тус тус сургалтад хамруулж нийт 1763 ажлын байр бий болсон байна. НҮБ-ын “Монгол Улсад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн хүрээнд “Арьс шир боловсруулах технологи”, “Хонины ноосыг машинаар хяргахад бэлтгэх нь”, “Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь”, “Хүхэрт устөрөгчийн хийтэй хэрхэн харьцах вэ”, “Гутлын зохион бүтээлт”, “Ажлын байр-цахим хосолсон сургалтыг хэрхэн зохион байгуулах, удирдах” зэрэг сургалтын хөтөлбөрүүдээр нийт 39 удаагийн сургалтыг 1600 гаруй хүнд хийж 10 гаруй сургалтын гарын авлага, товхимол боловсруулаад байна. Үүний үр дүнд сургалтад хамрагдсан хүмүүс мэргэжлийн ур чадвар, мэдлэгээ олон улсын сайн туршлагаар баяжуулж ажлын байрандаа эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг мөрдөн аливаа эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвартай болов. Түүнчлэн мэргэжлийн сэдвүүдээр бие даан сургалт зохион байгуулж хүний нөөцийг чадваржуулах нөхцөл бүрдлээ.</p> <p style="text-align: right;">ХШҮ – 70%</p> <p>4.10 Батлан хамгаалах цэргийн албан хаагчдыг үйлдвэрлэлийн дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажилд оролцуулах талаар зохих шатны төрийн байгууллагуудтай хамтран ажиллах.</p> <p>Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журам”-ыг боловсруулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн 2018 оны 01 дүгээр зарлигаар батлуулсан. Мөн “Автозамын бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах түр журам”-ыг боловсруулан сайдын 2018 оны А/217 дугаар тушаалаар батлуулснаар Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах эрх зүйн орчин бүрдсэн.</p> <p>ЗГ-ын 2018 оны 2, 21 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын 2018 оны 09 дүгээр тогтоолын хүрээнд Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрийн хүнд даацын тусгай зориулалтын авто замын барилгын ажлын гэрээг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-тай байгуулан ажиллаж байна. Уг бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай худалдан авалтыг Батлан хамгаалахын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А-201/169 дүгээр тушаалын дагуу зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Бүтээн байгуулалтын ажил батлагдсан гэрээ, төлөвлөгөөгөөр 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хүлээлгэж өгөх бөгөөд 2018 онд төлөвлөгдсөн ажлыг 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл үргэлжилж, төлөвлөгөөний дагуу явагдаж байна. Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар БХЯ-ны Зэвсэгт хүчний жанжин штабын дэргэд Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний бүтээн байгуулалтад оролцуулах төслийн баг байгуулан ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>Асрамж, халамжийн газарт өсөж хүмүүжсэн зорилтот бүлгийн иргэдийг үйлдвэрлэгчидтэй хамтран мини төсөлд хамруулах.</p> <p>Зорилтот бүлгийн залуучуудыг нийгэмшүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр олон нийгэд түшиглэсэн үйл ажиллагааг сайн дурын иргэдийн оролцоотойгоор зохион байгуулна” заалтыг үндэслэн Асрамж, халамжийн төвөөс насанд хүрч нийгмийн харилцаанд орж буй залуучуудыг дэмжих төслийг шинэчлэн, төлөвлөгөө гарган, ЗГХА “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар”-тай хамтран ажиллахаар 2 удаагийн уулзалтыг зохион байгуулав. Ингэхдээ аймаг, дүүрэг бүрт зорилтот бүлгийн тодорхой тооны залуучуудыг нийгмийн харилцаанд бэлтгэх зөвлөгөө, сургалтад хамруулах, бие даан амьдрахад тулгарах аливаа бэрхшээлийг даван туулах, мэргэжил эзэмших болон хөдөлмөрийн зах зээлд ороход зөвлөх буюу амьдралын зөвлөгчийн зөвлөгөө, дэмжлэгээр хангах зэргээр амьдрах байр, өдөр тутмын амьжиргааны зардлыг тусгасан цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, үүнд аймаг, дүүргүүдийн ГБХЗХГ болон ЗХТ-ийн оролцоог хангах байдлаар тусгаад байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p>
--	--	--

		<p>Гадаад оронд ажиллаж байсан, шинэ технологи эзэмшсэн иргэдийг эх орондоо иргэн ирж тухайн чиглэлээр үйлдвэрлэл явуулахад санхүү, татварын дэмжлэг үзүүлэх</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 сарын 27-ны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 4.4-т Гадаадад ажиллаж, амьдарч байгаад сүүлийн 2 жилийн дотор эх орондоо ирсэн иргэн өөрийн эзэмшсэн мэргэжил, ур чадварын дагуу гарааны бизнес эрхлэхийг дэмжих арга хэмжээг 2018 оноос хэрэгжүүлж байна. Уг арга хэмжээний хүрээнд 5.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 36 сарын хугацаанд эргэн төлөх нөхцөлтэйгөөр нэг удаа олгохоос гадна аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт, борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт арга хэмжээнүүдэд хамруулж байна. БНСУ-д ажиллаж амьдарч буй Монголчуудын эзэмшсэн мэргэжил, шинэ технологи, ноу хауг Монгол Улсад нутагшуулах зорилгоор төслийн уралдаан, Монголын үндэсний бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, экспортлох боломж нөхцлийг сайжруулах зорилгоор үзэсгэлэн худалдаа, бизнес эрхэлж буй залуусыг дэмжих, хоёр орны бизнесийн харилцан түншлэлийг өргөтгөх, зах зээлд хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор бизнес форумыг 2019.05.24-05.26 өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотод зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд 30 гаруй аж ахуй нэгжүүд ноос, ноолуур, арьс шир, хэвлэл, оёмол бүтээгдэхүүн, үндэсний хувцас, бэлэг дурсгалын 15 төрлийн 38 нэрийн бараа бүтээгдэхүүнээр оролцож 19.8 сая воны борлуулалт хийсэн</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>Шинээр байгуулагдсан болон өргөтгөх үйлдвэрийн ажилтны тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэхийн тулд төрийн байгууллага- ажил олгогч-ажилтны гурвалсан гэрээ байгуулж ажиллах.</p> <p style="text-align: right;">ХШҮ-0%</p> <p>4.14 Шинээр байгуулах үйлдвэрүүдэд ажиллах ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх /орон сууц, цалингийн тогтолцоо, урамшуулалт/ Мэргэжилтэй ажилтаны эрэлт хэрэгцээ өндөр байгаа тул үйлдвэр аж ахуйн нэгжүүд өөрсдийн санаачилгаар дараах үлгэр жишээ ажлыг эхлүүлээд байна. Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэлийн салбарын "Их газрын чулуу" ХХК нь Нутгийн ирээдүй оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг дараах 2 чиглэлээр зарласан байна. 1. Сарын тэтгэлэг /50 000₮/ болзол нь сар бүр 1 ном уншиж, хэлэлцүүлэгт оролцох, сард нэг дадлага ажил хийх, 2. Сургалтын төлбөрийн тэтгэлэг /2 000 000₮/ болзол нь ШУТИС-ҮТС-ийн Хувцас загвар зохион бүтээгч, технологич мэргэжлээр элсэгч байх, Сард нэг өдөр дадлага ажил хийх зэрэг шаардлага тавьж ажилтнаа бэлтгэх урамшуулах ажлыг зохион байгуулсан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p>
Зорилт 4-ийн дундаж үнэлгээ 71.4%		
<p>5-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Зорилтот зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний тээвэр-логистикийг боловсронгуй болгож, маркетингийг эрчимжүүлэн гадаад, дотоод худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх:</p>		<p>5.1 Гааль, татвар, мэргэжлийн хяналтын нэг цэгт үзүүлэх тогтолцоог бий болгох судалгаа хийх, гадны туршлагыг судлах.</p> <p>ГЕГ, МХЕГ-ын даргын 2019.04.16-ны өдрийн 01 дугаартай “Хамтран ажиллах санамж бичиг”-ийг байгуулж, хилийн үйлчилгээг сайжруулах, хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтарсан хяналт, шалгалт зохион байгуулах, харилцан мэдээлэл солилцох, мэдээллийн нэгдсэн сиситемийг уялдуулах цахим нэг цонхны суурь нөхцлийг бүрдүүлэхээр судалгааны ажлын хэсгийг хоёр талаас зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Гадаад худалдааны цахим нэг цонхны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд АХБ-ны санхүүжилтээр “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл” буюу “RIBS”- төслийн нэгжээс олон улсын зөвлөхийг авч МУ-д хэрэгжүүлэх цахим нэг цонхны хөтөлбөрийн төлөвлөгөөг боловсруулан 2 үе шаттайгаар тендер зохион байгуулахаар СЯ, ГЕГ-ын холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан тендерийн хороог 2019 оны 4 дүгээр сард байгуулан тендерийн ажлыг эхлүүлсэн.</p> <p>ГХЦНЦ-ны үйл ажиллагаатай танилцах арга хэмжээг Малайз, Сингапур улсад зохион байгуулж ГЕГ, МХЕГ-ын удирдах албан тушаалтнууд оролцсон. Арга хэмжээнд ЦНЦ-ны үйлчилгээг нэвтрүүлсэн туршлага, нэвтрүүлж эхлэх үед тулгарч байсан хүндрэл бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэсэн арга замын талаар судалсан. Малайзын уг үйлчилгээний хамрах хүрээ, түүний үйлчилгээний бизнесийн болон үйл ажиллагааны онцлог, байгууллагын оролцооны онцлог, ЦНЦ-ны үйлчилгээний системийн техникийн онцлог, Малайз, Сингапурын хилийн боомтын үйл ажиллагаатай танилцан туршлага судалсан.</p> <p>НӨАТ суутган төлөгчөөс ирүүлдэг НӨАТ-ын тайланд импортоор буюу гаалиар бараа оруулж ирсэнийг татвар төлөгч гараар шивж оруулдаг байсныг ГЕГ-тай хамтран байгуулсан гэрээний үндсэн дээр цахимаар шууд гаалийн серверээс татаж тайлагнах хөгжүүлэлтийг цахим татварын системд /e-tax.mta.mn/ хийж нэвтрүүлж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>5.2 Экспортын нэг цонхны бодлого хэрэгжүүлж, гааль, татвар, мэргэжлийн хяналт зэрэг төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр, эсхүл нэг цэгт үзүүлэх "цаасгүй бүрдүүлэлт"-г нэвтрүүлэх.</p>

		<p>Импортоор оруулж бараа, бүтээгдэхүүнийг бүртгэхдээ БТКУС-ын код дээр суурилсан шинэ барааны кодыг Цахим төлбөрийн системд нэвтрүүлж байна. Төлбөрийн баримт хэвлээгүй бол хил гаалиар гарах боломжгүй байхаар хяналтыг хийхээр хөгжүүлэлт хийх холбогдох журам, аргачлалд нэмэлт оруулж тодорхойлсноор нэвтрүүлэх боломжтой.</p> <p>Экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанар, агууламжийг үйлдвэрлэгчээс урьдчилан тодорхойлуулан хилээр гарах үед бүхий л шаардлагатай мэдээллийг цуглуулах, импортын бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгч хүртэл татварын удирдлагын нэгдсэн систем болон гаалийн мэдээллийн системд тулгуурлан бүртгэлжүүлэх програм хангамжийг хөгжүүлж, олон улсын стандартад нийцсэн зураасан код ашиглан татварын цахим төлбөрийн баримтын систем нэвтрүүлэх ажлыг гаалийн байгууллага хийж гүйцэтгэж байна.</p> <p>БНСУ-ын Үндэсний гаалийн мэдээллийн сүлжээний үйл ажиллагааны холбоо (CUPIA)-ноос хэрэгжүүлж байгаа “Гаалийн байгууллагын шинэчлэл” төслийн багийг ханд гаалийн бүрдүүлэлтийн CAIS програмд гаалийн бүрдүүлэлт хэрхэн хийгдэж байгаа талаар өмнө нь 3 удаа уулзаж ярилцсан бөгөөд 2019.09.17-нд дээрх төслийн баг ирээдүйн загварыг танилцуулсанд саналаа өгч хэлэлцсэн. Системийг боловсронгуй болгож, нийтдээ 22 ажлыг хийх шаардлагатай гэж үзсэн бөгөөд үүнд цахим нэг цонхны хөтөлбөр хэрэгжүүлэх ажил багтсан болно.</p> <p>Татварын алба нь 2019 оны 03 сарын 01-нээс Татварын удирдлагын нэгдсэн системийг хэрэгжүүлж эхэлснээр татвар төлөгчөөр бүртгүүлэх, татварын төлөлтийг татварын албанд, банкинд өөрийн биеэр очихгүйгээр цахимаар хийх боломжийг бүрдүүлсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>5.3 Үндэсний үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг олон улсын худалдааны сүлжээнд хамруулах боломжийг судлах, худалдааны сүлжээнд хамруулах</p> <p>Худалдааг хөнгөвчлөх Үндэсний хорооны IV хуралдааныг 2019.04.10-ны өдөр ГХЯ-нд зохион байгуулж, ХХААХҮЯ, ГЕГ, МХЕГ, СХЗГ, ХХМТГ, ҮХГ, МҮХАҮТ-ын төлөөлөл, АХБ-ны “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн зохицуулагч нар оролцов. Худалдаатай холбоотой мэдээллийн ил тод байдлыг хангах “Гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн сан” болон гадаад худалдаанд оролцогч байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах “Цахим нэг цонхны систем”-ийг байгуулах асуудал багтав. Түүнчлэн манай улсаас ММБ-ийг хилээр нэвтрүүлэх үед тулгарч буй асуудал болон Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрт МУЛс нэгдэн орох шаардлагын талаар мэдээлэл солилцож, харилцан ярилцаж холбогдох шийдвэр гаргахаар болов.</p> <p>Импортоор оруулж бараа, бүтээгдэхүүнийг бүртгэхдээ БТКУС-ын код дээр суурилсан шинэ барааны кодыг Цахим төлбөрийн системд нэвтрүүлж байна. Төлбөрийн баримт хэвлээгүй бол хил гаалиар гарах боломжгүй байхаар хяналтыг хийхээр хөгжүүлэлт хийгдэхээр байна. Холбогдох журам, аргачлалд нэмэлт оруулж тодорхойлсноор нэвтрүүлэх боломжтой.</p> <p>НҮБ-ын АНДЭЗНКомисс (UNESCAP)-оос “Бүс ба Зам санаачилга, бүс нутгийн интегралчлал, тогтвортой хөгжил, эдийн засгийн коридорын дагуу хилийн цаасгүй худалдааг хөгжүүлэх” төслийн хүрээнд МУ-ын цаасгүй худалдаа, худалдааг хөнгөвчлөх чиглэлээр бүс нутгийн хэмжээнд урагшлах, хил дамнасан цаасгүй худалдааны хууль эрх зүйн орчин, техникийн бэлэн байдлын үнэлгээ болон сонгосон чиглэлд экспорт, импортын процедурын судалгааг хийсэн.</p> <p>Төслийн хүрээнд Монголын экспортлогчдыг шинэ зах зээлд нэвтрэх, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сурталчлах, зах зээлээ өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, гадаад түнштэй холбох зорилгоор МҮХАҮТ-тай хамтран "MONGOLIAN EXPORTERS-2018" цахим каталогийг боловсруулан exporters.mongolchamber.mn цахим хуудсаар болон CD хэлбэрээр танилцуулж байна. Цахим каталогт МУ-ын 100 гаруй ААН-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээг 9 салбарт ангилан танилцуулга, зураг хэлбэрээр оруулснаас гадна экспортын зарим баримт бичгүүдийн загвар зэрэг мэдээллүүдийг багтаасан болно. Ингэснээр олон улсын бизнес уулзалт, үзэсгэлэн яармагийн арга хэмжээ, Монголд болон гадаадад суугаа ЭСЯ, худалдааг дэмжих байгууллагууд, МҮХАҮТ-ын гадаад орнууд дахь төлөөлөгчдөөр дамжуулан дэлхийн зах зээлд үнэ төлбөргүй сурталчлах боломжтой болсон.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>5.4 Европын холбоо, АНУ-н ХЕС болон Монгол Японы ЭЗТХ-ийн хүрээнд үндэсний үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх судалгааг хийх, дэмжлэг үзүүлэх</p> <p>“Монголын Цагаан сар” арга хэмжээг АНУ-ын Конгрессын байранд 2019.02.04-нд зохион байгуулж, Цагаан ордон, Конгресс, Төрийн департамент, БХЯ, Худалдааны яамны төлөөлөл болон Монголыг дэмжиж хамтран ажилладаг 200 гаруй хүн оролцсон. Уг арга хэмжээ нь “Гуравдагч хөршийн худалдааг дэмжих тухай хууль”-ийг батлуулах ажлыг урагшлуулахад чухал ач холбогдолтой болов. Дээрх хуулийн төслийг Конгрессын хоёр танхимд 2019 оны 4 дүгээр сард дахин өргөн барив. Хуулийн төсөл Конгрессын хоёр Танхимд хоёр намын дэмжлэгийг аваад байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар төсөлд 55 гишүүн хамтран зохиогчоор ороод байна.</p>
--	--	---

	<p>Японд уламжлал болгон зохион байгуулагддаг “TOURISM EXPO JAPAN”, Хавар, намрын “FOODEX JAPAN”, “TOKYO FASHION WORLD”, “IFF Magic”, “Tokyo International Industry Exhibition 2017”, “Eco-pro 2017” зэрэг олон улсын экспод жил бүр монголын компаниуд оролцож байна. МННХ-ны гишүүн компаниуд хавар, намрын “TOKYO FASHION WORLD” олон улсын үзэсгэлэнд сүүлийн 3 жил дараалан оролцож байна. ЭСЯ Японы ЭЗҮХЯ-тай хамтран ноолууран бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн хяналт, шинжилгээний чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, мэргэжилтэн томилон ажиллуулж байна. Сургалтаар Японы “Нэгдсэн чанарын хяналт /TQC/, тоног төхөөрөмжийн програмчлал, ашиглалт, засвар үйлчилгээ, хөдөлмөрийн хяналт, менежмент, хүний нөөцийг хөгжүүлэх, японы хэрэглэгчдийн хандлага, зах зээлийн судалгаа хийх аргачлал зэрэг агуулгаар хийв.</p> <p>EXU-аас хэрэгжүүлж байгаа TRAM төслөөс МУ-аас экспортлох боломжтой бараа бүтээгдэхүүнийг судалж мах, чацаргана, ноос ноолуур, гоо сайхан, аялал жуулчлалын чиглэлийн 5 кластераар хөгжүүлэх чиглэл гарч судалгаа хийгдсэн. АХБ-наас хэрэгжүүлж буй ХАА-н НӨС-г дэмжих ТТ-ны төслийн хүрээнд “Чацарганы гадаад зах зээлийн судалгаа”-ны ажлын гэрээг Бодлогын шийдэл ТББ-тай байгуулж ажлыг эхлүүлэв.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>5.5 Монгол Улсаас ОХУ-д нийлүүлэх бүтээгдэхүүний тарифын болон тарифын бус хориг саадыг бууруулахад чиглэгдсэн үйл ажиллагааг шат дараалалтайгаар зохион байгуулах</p> <p>Монгол, Оросын худалдааны хэмжээ 2017 онд 1,28 тэрбум ам.доллар, 2018 онд 1.79 тэрбум ам.долларт тус тус хүрч, 39 хувиар нэмэгдэв.</p> <p>МУ-ын Ерөнхийлөгч Х.Баттулгын ивээл дор зохион байгуулагдсан “Монгол - Оросын санаачилга 2018” цуврал арга хэмжээний хүрээнд Оросын дэвшилтэт техник, технологи, хөдөө аж ахуйн техникийн үзэсгэлэнг 2018 оны 6 дугаар сард Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Оросын талаас бизнесын 130 гаруй төлөөлөгч, монголын талаас 400 гаруй компанийн төлөөлөгч оролцсон.</p> <p>Монгол Улсаас ОХУ-д нийлүүлэх бүтээгдэхүүний тарифын болон тарифын бус хориг саадыг бууруулахад чиглэгдсэн саналыг яриа хэлэлцээний бүхий л түвшинд илэрхийлж байна. ОХУ-ын зүгээс Евроазийн эдийн засгийн холбооны хүрээнд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах замаар асуудлыг шийдвэрлэх нь зохистой гэсэн санааг удаа дараа илэрхийлсэн бөгөөд Евразийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах хамтарсан судалгааны ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн 2019 оны 12 дугаар сард ОХУ-д хийсэн айлчлалын хүрээнд Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хоорондын Бизнес форум, Монголд үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний үзэсгэлэнг Москва хотноо зохион байгуулав. Бизнес форум, үзэсгэлэнд манай бизнес эрхлэгчдийн төлөөлөл 50 гаруй хүн оролцож, МҮХАҮТ болон аж ахуйн нэгжүүд ЕАЭЗХ, ОХУ-ын түнш байгууллагуудтай 10 орчим баримт бичиг байгуулав.</p> <p>Монгол-Оросын хамтарсан “Baikal trade 2019” олон улсын форумыг 3 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд ОХУ-ын Улаан-Үд хотод зохион байгуулав. Форумын хүрээнд зохион байгуулсан Монгол Улсын экспортын бараа бүтээгдэхүүний үзэсгэлэнд хүнс, хөнгөн үйлдвэрийн чиглэлийн 22 аж ахуйн нэгж өөрсдийн бараа бүтээгдэхүүнээ танилцуулав.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40%</p> <p>5.6 Монгол брэнд бүтээгдэхүүнийг дэлхий нийтэд сурталчлах, таниулах "Хаан ширхэгт" брэндийг үйлдвэрлэн, гэрчилгээ олгох, сурталчлах</p> <p>“Монголын хаан ширхэгт” брэндийг хөгжүүлж, зах зээлд таниулах, сурталчлах" үйл ажиллагааны хүрээнд АХБ-ны ХАА нэмүү өргийн сүлжээг хөгжүүлэх төсөл, МННХ-той хамтран ажиллаж байна.</p> <p>МХШ чанарын тэмдэгт бүтээгдэхүүнийг баталгаажуулах хөтөлбөр, хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалтыг шинээр боловсруулсан;</p> <p>Бүтээгдэхүүний чанарт нийцэх түүхий эдийг бэлтгэх технологийн сургалтын 3 модуль боловсруулж, нийт 14 сургалтаар 4 аймгийн 18 хоршоодын 578 малчин, хоршооны сургагч багш нарыг чадавхжуулсан;</p> <p>Ээрмэл, нэхмэл, сүлжмэлийн чанар, хяналтын болон гүйцэтгэн боловсруулалтын технологийн сургалтын 5 модулийг ААН бүрийн онцлогт суурилан боловсруулж, нийт 16 сургалтыг 15 ААН-ийн ажлын байранд зохион байгуулж, нийт 371 ИТА-ны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн;</p> <p>Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний тохирлын үнэлгээний баталгаажуулалт хийх эрх бүхий байгууллага бий болгох, тэмдэг ашиглах, эрх авах аж ААН-ийн үйлдвэрлэлийн чанар болон техникийн ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, итгэмжлэгдсэн сорилын лабораторийн техник тоног төхөөрөмж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, гэрчлэх тэмдэг бүхий бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах арга хэмжээг хамтран зохион байгуулж байна.</p>
--	--

	<p>“Монголын хаан ширхэгт” ноолуурын олон улсын форумыг зохион байгуулж, тохирлын баталгаатай, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд халгүй, чанар аюулгүйн стандартын шаардлага хангасан ээлтэй бүтээгдэхүүн хөгжүүлэх, улмаар олон улсын зах зээлд танигдсан нэр хүндтэй бренд болгох үйл ажиллагаа эхлүүлээ. Тус арга хэмжээнд 17 улсын ЭСЯ, үндэсний үйлдвэрлэгчид, малчдын хоршооны төлөөлөл, судлаачид, төрийн болон ТББ, ОУ-ын худалдан авагчид, төсөл, хөтөлбөрүүдийн төлөөлөл нийт 350 гаруй хүн оролцлоо.</p> <p>АНУ-ын нийслэл Вашингтон хот дахь Дэлхийн банкны үндсэн цогцолборт “Монголын өв соёлын өдрүүд”, “Монголд үйлдвэрлэв-2019” үзэсгэлэн худалдаа, бизнес форумыг Экспорт Олон улсын худалдааны төв, ХХААХҮЯ, ГХЯ, ЖДҮХС, ХААБ, М -аас АНУ-д суугаа ЭСЯ хамтран зохион байгууллаа.</p> <p>МННХ нь Япон улсын “Fashion World Tokyo” болон АНУ-ын “Coterie” олон үзэсгэлэнд компаниудыг зохион байгуулж оролцууллаа.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>5.7 "Нэг сум-нэг бренд" аян өрнүүлэх.</p> <p>Архангай, Баянхонгор, Завхан, Хэнтий аймагт "Нэг суурин-нэг бахархал" аяныг өрнүүлэн сумдын шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Шилдэг бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг шалгаруулан үйлдвэрлэгч нарыг идэвхжүүлэх аяны хүрээнд сургалт, үзэсгэлэн худалдааг жилд 2-оос доошгүй зохион байгуулсан байна.</p> <p>НИТХТХ-аар батлагдсан "Улаанбаатарт үйлдвэрлэв" дэд хөтөлбөрийн хүрээнд ЖДҮ эрхлэгчдийн борлуулалтыг үе шаттайгаар нэмэгдүүлж бүтээгдэхүүний чанар стандартыг сайжруулах, шинэлэг бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжилтийг ханган ажиллаж байна. "Улаанбаатарт үйлдвэрлэв." үзэсгэлэн худалдааг 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 553 аж ахуйн нэгж, иргэнийг хамруулж үзэсгэлэн худалдааны түрээсийн төлбөрийг хөтөлбөрийн санхүүжилтээс шийдвэрлэн үйлдвэрлэгч нарыг үнэ төлбөргүй хамруулж бараа бүтээгдэхүүний чанар, стандарт баглаа боодлыг сайжруулах тал дээр байнгын зөвлөгөө өгч ажиллав. Үзэсгэлэн худалдаанд оролцсон үйлдвэрлэгчдээс шинэ санаа, шилдэг технологийг нэвтрүүлсэн цаашдын дотоодын төдийгүй гадаад зах зээлд борлуулах боломжтой 9 үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг шилдэг үйлдвэрлэгчээр шалгаруулан НЗД-ын батламж гардуулсан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p> <p>5.8 Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг худалдааны түнш орнуудад сурталчлах, ЭКСПО-д оролцоход дэмжлэг үзүүлэх</p> <p>Япон улсын Токио хотноо зохион байгуулагддаг “Fashion World Tokyo”, АНУ-ын Нью Йорк хотноо зохион байгуулагддаг “Fashion Coterie” олон улсын үзэсгэлэнд 2, 10 дугаар саруудад ноос, ноолуурын үйлдвэрүүдийг “Mongolian Cashmere” нэгдсэн нэрийн дор зохион байгуулж оролцуулахад МННХ-той хамтран ажилласан ба тус улсуудад гаргаж буй экспортын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 20-30% нэмэгдсэн байна. Мөн дотооддоо “Монгол экспорт экспо” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, үзэсгэлэн худалдаанд ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 40 гаруй аж ахуйн нэгжийг оролцуулсан ба энэ үеэр 180 сая гаруй төгрөгийн борлуулалт хийгдсэн.</p> <p>ГХЯам, Япон улсын Токио хот дахь Монгол улсын Элчин сайдын яам, ХХААХҮЯамны харьяа ЖДҮХСан, Хөгжлийн банк, Экспорт олон улсын худалдааны төв байгууллагууд хамтран 2018 оны 6 дугаар сард Япон улсын Токио хотод “Монгол-Японы бизнес форум” үзэсгэлэнгийн арга хэмжээг зохион байгуулсан. Тус Форумд Япон улсаас Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Жижиг дунд бизнесийг дэмжих төв байгууллага тэргүүтэй 120 гаруй бизнес эрхлэгчид, Монгол улсаас 15 байгууллага оролцсон.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>5.9 "Монгол-Хятадын Экспо"-г тогтмол зохион байгуулах.</p> <p>БНХАУ-ын Худалдааны яам, ӨМӨЗО-ны Ардын Засгийн газартай хамтран “Монгол-Хятадын Экспо” 2, 3 дах удаагийн арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.</p> <p>“Монгол-Хятадын Экспо” III удаагийн арга хэмжээг 2019 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот, Улаан цав хотуудад зохион байгуулахад Монголын талаас 450 ААН-ийн 720 орчим үндэсний үйлдвэрлэгчид оролцсон ба нийт 7,2 юань буюу 2,7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн. Арга хэмжээний “Бүс нутгийн хамтын ажиллагаа, эдийн засаг, худалдаа хөрөнгө оруулалтын чуулга уулзалт”-д МУЗГ-ын томоохон 15 төсөл хөтөлбөр, хувийн хэвшлийн ААН, байгууллагын 56 төслийг БНХАУ-ын болон бусад улсын бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдад танилцуулсан. Мөн 2017 оны “Монгол-Хятадын Экспо”-ийн хүрээнд түншилсэн манай 50 гаруй аж ахуйн нэгж хамтын ажиллагааны гэрээ, санамж бичигт гарын үсэг зурсан юм.</p> <p>“Монгол-Хятадын Экспо” арга хэмжээ нь Монгол, Хятад хоёр улсын эдийн засаг, хамтын ажиллагааны хөтөлбөрт тусгасан худалдааны эргэлтийг 2020 онд 10 тэрбум ам.долларт хүргэх зорилтыг хэрэгжүүлэхэд түлхэц болсон, эдийн засгийг өргөжүүлэн хөгжүүлэх гарцыг эрэлхийлсэн, үндэсний үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг таниулан сурталчилж, худалдаа, бизнесийн харилцааг өргөжүүлэх.</p>
--	--

		<p>харилцан туршлага солилцож, шинэ түншлэлийг бий болгон, хамтын ажиллагааг хөгжүүлэх өндөр ач холбогдолтой арга хэмжээ болсон юм. ХШҮ-100%</p> <p>5.10 Үндэсний үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх худалдааны нэгдсэн портал сайт, аппликейшн бий болгох.</p> <p>“Улаанбаатар инновацийн төв”-д бойжиж буй гарааны компани болох “Амар и коммерси” ХХК-иас үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах худалдааны онлайн сайтыг 2018 онд хийж гүйцэтгэсэн. Тус онлайн худалдааны Авлаа.мн сайтад дотоод, гадаадын 1200 гаруй бренд бүтээгдэхүүнийг байршуулан, 2018.03.15-нд нээлтээ хийж үйл ажиллагаагаа эхлүүлэн ажиллаж байна. Алибаба компанид хамтран ажиллах санал хүргүүлсэн. 2018.01.17-ны өдөр Аж үйлдвэрийн цахим мэдээллийн системд үйлдвэрлэгчдийн мэдээллийг нэгтгэх ажлыг эхлүүлсэн бөгөөд 2019 оны байдлаар 3700 үйлдвэр мэдээллээ системд оруулсан. ҮХГ, Оюун толгой компани Аж үйлдвэрийн цахим мэдээллийн санг ашиглах тухай харилцан ойлголцлын санамж бичиг зурсан. Тус цахим системийг "Оюу толгой" ХХК-ийн худалдан авалтын "Монголд үйлдвэрлэв" бодлогын хүрээнд Монгол улсад үйлдвэрлэл эрхэлж буй үйлдвэрлэгчид болон зах зээлийн талаарх судалгаа, шинжилгээ хийх болон худалдан авалтын зарыг илүү оновчтой түгээх үйл ажиллагаанд ашиглах боломжтой болно. Мөн үйлдвэрлэл эрхлэгчдийг гадаад худалдаа, хөрөнгө оруулагч нарт сурталчлах, мэдээ мэдээлэл түгээх зорилготойгоор "Германы Олон Улсын Нийгэмлэг GIZ"-ийн Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачилга төсөлтэй хамтран Аж үйлдвэрийн цахим мэдээллийн санг хөгжүүлж байна. ХШҮ-100%</p> <p>5.11. УБ хотын баруун, зүүн талд мал эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, ногооны төрөлжсөн бөөний худалдааны төв байгуулахад дэмжлэг үзүүлэх.</p> <p>Улаанбаатар хотын нийт махны хэрэглээний 10-15 хувийг хангах /1500 бод, 7500 богийн/ хүчин чадал бүхий мал нядлах үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр, мал зарах задгай талбай бүхий үйлдвэрийн цогцолбор барилгын төслийг 2017 онд эхлүүлсэн. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд "МБҮ Трейд" ХХК-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. НЗД-ын 2017 он А/516 дугаар захирамжаар 21.2 га газрыг СХД-ийн 32, БЗД-ийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт шийдвэрлүүлэн тус компанитай газар ашиглах гэрээг байгуулсан.</p> <p>Төслийн ТЭЗҮ болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, байгаль орчны үнэлгээ батлагдан, ажлын зураг төсөл хийгдсэн. Зүүн бүсийн барилга угсралт, үйлдвэрийн барилга баригдсан бөгөөд инженерийн шугам сүлжээ татагдсан. Баруун бүсийн барилга угсралтын ажлын хувьд нийт 260.0 мян.м3 газар шороо тэгшилгээний ажил дууссан. Барилгын суурийн ажил, металл /карказ/ угсалтын ажил 100 хувийн гүйцэтгэлтэй, сэндвич хавтанг угсрах бэлтгэл ажил 70, суурийн өрлөгийн ажил 60, шалны цутгалтын ажил 50, гадна зам талбай, гадна инженерийн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, цахилгааны ажлууд 30-40 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.</p> <p>Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, мах, махан бүтээгдэхүүний хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулах ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж, Гүйцэтгэгчээр шалгарсан “ХБХДТ” ХХК -тай гэрээ байгуулж ажил хүлээж авсан. ХШҮ-100%</p> <p>5.12. Сав, баглаа боодлын захиалгын болон худалдааны цэгийг байгуулахад дэмжлэг үзүүлэх.</p> <p>Аймаг болон бүс нутагт бүрт сав баглаа боодлын захиалгыг нийлүүлэх, худалдаалах төвийг хүнсний захуудыг түшиглэн байгуулах санаачлагыг гялгар уут, цаасан, даавуун тор үйлдвэрлэгчид болон модон хувин, хүнсний зориулалтын хуванцар сав үйлдвэрлэгчид хамтран кластер хэлбэрээр зохион байгуулахаар Монголын сав баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо санаачлага гарган, саналаа ирүүлснийг яамны зүгээс дэмжин нийт аймагуудад хүргүүлсэн. ХШҮ-40%</p>
	Зорилт 5-ийн дундаж үнэлгээ 87.5%	
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, асуудлууд)	<p>1. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн 2019 оны жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний ерөнхий дундаж 76.4 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээгээр дүгнэгдэв.</p> <p>2. Шалгуур үзүүлэлтийн биелэлтийг авч үзвэл: Нийт экспортоп боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь 33.3, арьс ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 11.1, ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 26.0 хувиар,</p>

		<p>Хүн амын хэрэгцээнд үйлдвэрийн аргаар боловсруулж нийлүүлсэн мах, сүүний үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ 3.3-88.8 хувиар тус тус өссөн дүнтэй байна.</p> <p>Шинээр байгуулагдсан үйлдвэр: ЗГ-ын 36 дугаар тогтоолын хавсралтад батлагдсан үйлдвэрээс бүрэн ашиглалтад орсон 42, бүтээн байгуулалтын ажил хийгдэж буй 19, нийт 61 үйлдвэр бий болсон. Хөтөлбөрийн 5.4-т “Хөтөлбөр хэрэгжих явцад улсын болон орон нутгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын орчин зэргээс шалтгаалан үр ашиг, ач холбогдол бүхий шинээр байгуулсан үйлдвэрийг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйлдвэрийн тоонд тооцож болно” гэж заасны дагуу ЖДҮХС, ОНХС, гадны хөрөнгө оруулалтаар 11 үйлдвэр ашиглалтад орж, нийт 72 үйлдвэр 2018-2019 онд байгуулагдсан байна.</p> <p>Ажлын байр 3700-аар нэмэгдсэн зэргээс авч үзэхэд “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр зорилтот түвшиндээ хүрэх боломжтой хэмээн дүгнэж байна.</p> <p>Ололттой тал: Худалдааг хөнгөвчлөх Үндэсний хорооны IV хуралдаанаар Худалдаатай холбоотой мэдээллийн ил тод байдлыг хангах “Гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн сан” болон гадаад худалдаанд оролцогч байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах “Цахим нэг цонхны систем”-ийг байгуулах асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргасан. Түүнчлэн манай улсаас мах, махан бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэх үед тулгарч буй асуудал болон Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орох шаардлагын талаар мэдээлэл солилцож, харилцан ярилцаж холбогдох шийдвэр гаргах болсон нааштай эхлэл гарч байна.</p> <p>Импортоор оруулж бараа, бүтээгдэхүүнийг бүртгэхдээ БТКУС-ын код дээр суурилсан шинэ барааны кодыг Цахим төлбөрийн системд нэвтрүүлж байна. Төлбөрийн баримт хэвлээгүй бол хил гаалиар гарах боломжгүй байхаар хяналтыг хийхээр хөгжүүлэлт хийгдэхээр байна. Холбогдох журам, аргачлалд нэмэлт оруулж тодорхойлсноор нэвтрүүлэх боломж бүрдэж байна.</p> <p>Дутагдалтай тал, тулгамдсан асуудал:</p> <ul style="list-style-type: none"> - Үндэсний хөтөлбөрийн биелэлтэд ирүүлж буй тайланд санхүүгийн гүйцэтгэлээ тусгахгүй байгаа нь нэгтгэх дүгнэх, төлөвлөхөд хүндрэлтэй байна. - “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөрийг яаралтай боловсруулж, батлуулах шаардлагатай. 						
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, аймаг, нийслэлийн ЗДТГ, ОУ-ын төсөл хөтөлбөрүүд, үйлдвэр аж ахуй нэгж, иргэд хөтөлбөрийн зорилго, зорилтын хүрээнд хийгдэж байгаа хамтын ажиллагаа, уялдаа холбоог “Хангалттай” гэж үнэлж байна.						
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
		77.5%	5	78.6 %	80.0 %	70.0 %	71.4%	87.5%
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ ... %						

Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн биелэлт

№	Шалгуур үзүүлэлт	нэгж	Суурь түвшин, 2016 он	Зорилтот түвшин, 2021 он	2019* онд	Биелэлт, %	
						Суурь түвшинтэй харьцуулахад	Зорилтот түвшинтэй харьцуулахад

1.	Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин	хувь	9	15	12	133.3	80,0
2.	Арьс, ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин	хувь	36	60	40 АШҮХ-оос	111.1	66,7
3.	Ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин	хувь	20	60	25.2	126.0	42,0
4.	Хүн амын хэрэгцээнд үйлдвэрийн аргаар боловсруулж нийлүүлсэн махны үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ	хувь	6	30	6.2*	103.3	38,0
5.	Хүн амын хэрэгцээнд үйлдвэрийн аргаар боловсруулж нийлүүлсэн сүүний үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ	хувь	9	40	17.0	188.8	42,5
6.	Шинээр байгуулагдсан үйлдвэрийн тоо	тоо	-	100	61.0	-	61.0
7.	Шинээр бий болгох ажлын байр (хүний тоо)	тоо	-	6000	3700	-	61.7
8.	Олон улсын түвшинд хүрсэн стандартын нийт стандартын дүнд эзлэх хэмжээ	хувь	42	50	37.2	-	

ЗӨВЛӨМЖ

1. Цаашид үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг эрчимжүүлж, шаардагдах санхүүжилтийг улсын төсөв болон “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн жил бүрийн төсөвт суулгаж батлуулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,

2. Үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг улсын төсөв болон “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн жил бүрийн төсөвт суулгаж, батлуулах,

3. Хөгжлийн банк, гадаадын төслүүдтэй хамтын ажиллагаагаа сайжруулж, үйлдвэрлэгчдэд эргэлтийн хөрөнгийн зээлийн дэмжлэгийг олгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх,

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс биелэлт удаашралтай болон тасарч байгаа арга хэмжээг дараагийн жилд хийх ажлын төлөвлөгөөнд тусгаж бүрэн хэрэгжүүлэх,

5. Хөнгөн үйлдвэрийн /ноос, ноолуур, арьс шир, оёдол, мод, модон материал г.м/ салбарын бодит статистик мэдээлэлтэй болох чиглэлээр ҮСХ-той хамтран ажилах,

6. Хөнгөн үйлдвэрийн нэгдсэн мэдээллийн сантай болохыг ХҮХБХЗГ-т зөвлөж байна.